

**АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БОЛОН БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 06 дугаар сарын 24-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 4-33

1. “Тавантолгой түлш” ХХК-ийн үйлдвэрлэл, технологийн үйл ажиллагааны талаар шалган судлах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий хянан шалгах ажлын хэсгийн санал, дүгнэлт 6-33

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Аж үйлдвэржилтийн бодлогын болон Байгаль орчин, хүнс,
хөдөө аж ахуйн байнгын хороодын хамтарсан
06 дугаар сарын 24-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Бейсен ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 42 гишүүнээс 22 гишүүн хүрэлцэн ирж, 52.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 59 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: П.Батчимэг, Г.Ганбаатар, Г.Лувсанжамц, П.Мөнхтулга;
Чөлөөтэй: О.Амгаланбаатар, Т.Аубакир, Д.Батбаяр, Д.Батлут,
Ц.Даваасүрэн, Х.Жангабыл, Д.Жаргалсайхан, Ц.Мөнхбат;
Эмнэлгийн чөлөөтэй: Н.Наранбаатар;
Тасалсан: Ж.Бат-Эрдэнэ.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу хэлэлцэх асуудлын 1 дүгээрт орсон Өвөлжилтийн бэлтгэлийг хангах хүрээнд хийгдэж байгаа ажлын талаарх Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мэдээллийг сонсох асуудлыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар хуралдаанд ирээгүй тул хойшлуулах горимын санал гаргав.

Б.Бейсен: Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуугийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	12
Татгалзсан:	13
Бүгд:	25

48.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Бейсен: Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	12
Бүгд:	25

52.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Бейсен: Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуугийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	12
Бүгд:	25

50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Нэг. “Тавантолгой түлш” ХХК-ийн үйлдвэрлэл, технологийн үйл ажиллагааны талаар шалган судлах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий хянан шалгах ажлын хэсгийн санал, дүгнэлт

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч А.Амартүвшин, Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын дарга Д.Мөнхбаатар, “Тавантолгой түлш” ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Ц.Эрдэнэбаяр, мөн компанийн ерөнхий технологич Д.Өлзийбат, Хөрөнгө оруулалт, төлөвлөлт, эдийн засгийн хэлтсийн дарга Х.Ариунзаяа, “Монгол төмөрлөг нийгэмлэг” ТББ-ын тэргүүн Ц.Бээжин нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, референт Г.Баярмаа нар байлцав.

“Тавантолгой түлш” ХХК-ийн үйлдвэрлэл, технологийн үйл ажиллагааны талаар шалган судлах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий хянан шалгах ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяа танилцуулав.

Санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Ж.Батжаргал, Б.Бат-Эрдэнэ, Д.Энхтуяа, Р.Батболд, Б.Пунсалмаа, Ө.Шижир, Г.Очирбат нарын тавьсан асуултад Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч А.Амартүвшин, Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын дарга Д.Мөнхбаатар, “Тавантолгой түлш” ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Ц.Эрдэнэбаяр, мөн компанийн ерөнхий технологич Д.Өлзийбат нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен, Ө.Шижир, З.Мэндсайхан, Д.Үүрийнтуяа нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд “Тавантолгой түлш” ХХК-ийн үйлдвэрлэл, технологийн үйл ажиллагааны талаар шалган судлах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий хянан шалгах ажлын хэсгийн санал, дүгнэлтийг сонсов.

Уг асуудлыг 15 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хороодын хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 59 минут үргэлжилж, ирвэл зохих 42 гишүүнээс 28 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр 15 цаг 58 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

С.ГАНБААТАР

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.БЕЙСЕН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

*2025 оны 06 дугаар сарын 24-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим
13 цаг 59 минут.*

АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БОЛОН БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Бейсен: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж ирц 52,4 хувьтай бүрдсэн тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороодын 2025 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн хамтарсан хуралдааныг нээснийг мэдэгдье. Хуралдааны ирцийг танилцуулъя. Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн ирсэн байна, Буланы Бейсен гишүүн ирсэн байна, Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн ирсэн байна, Цагаанхүүгийн Идэрбат гишүүн ирсэн байна, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн ирсэн байна, Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн ирсэн байна, Агваанлуvsангийн Ундраа гишүүн ирсэн байна, Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн ирсэн байна, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн ирсэн байна, Дуламын Бум-Очир гишүүн ирсэн байна, Сонгобайн Замира гишүүн ирсэн байна, Сүрэнжавын Лүндэг гишүүн ирсэн байна, Бадрахын Найдалаа гишүүн ирсэн байна, Ренчинбямбын Сэддорж гишүүн ирсэн байна, Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн ирсэн байна, Жигжидийн Батжаргал гишүүн ирсэн байна, Сайнхүүгийн Ганбаатар гишүүн ирсэн байна, Жаргалсайханы Золжаргал гишүүн ирсэн байна, Мэндбаярын Мандхай гишүүн ирсэн байна, Ухнаагийн Отгонбаяр гишүүн ирсэн байна, Буяагийн Тулга гишүүн ирсэн байна, Доржзодовын Энхтуяа гишүүн ирсэн байна.

Хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал энэ хамтарсан хурлаар 2 асуудал хэлэлцэнэ. 1 дүгээрт өвөлжилтийн бэлтгэл хангах хүрээнд хийгдэж байгаа ажлын талаарх Нийслэлийн Засаг дарга, Улаанбаатар хотын захирагчийн мэдээллийг сонсох. 2 дахь нь Тавантолгой түлш ХК-ийн үйлдвэрлэл технологийн үйл ажиллагааны талаар шалган судлах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий бүхийг хянан шалгах ажлын хэсгийн санал, дүгнэлтийг сонсох ийм 2 асуудал байгаа.

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүн байна уу? Лодойсамбуу гишүүнээр тасаллаа. Хэлэлцэх асуудалд оръё. Өвөлжилтийн бэлтгэлийн хангах хүрээнд хийгдэж байгаа ажлын талаар Нийслэлийн Засаг дарга, Улаанбаатар хотын Захирагчийн мэдээллийг сонсох. Ажлын хэсэг оруулъя. Ажлын хэсгээ дуудсан уу? Хэлсэн юм уу? Асуусан, юу гэж байна вэ? Пүрэвжавын Ганзориг гишүүн ирсэн байна. Энэ ажлын хэсгийнхэн Байнгын хорооны гишүүдийг хүлээлгээд яагаад оройтож байж байна вэ?

Ажлын хэсгийн нэрс танилцуулъя. Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо Санжаагийн Даваасүрэн Ажлын албаны дарга, Сандагийн Төмөрбат Бодлого, төлөвлөлт, биелэлт хариуцсан ахлах мэргэжилтэн, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар Амгаланбаярын Амартүвшин Нийслэлийн Засаг даргын

нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч, Даваасамбуугийн Мөнхбаатар Нийслэлийн агаар орчны бохирдолтой тэмцэх газрын дарга, Ганболдын Батзориг Улаанбаатар хотын ерөнхий менежер, Захирагчийн ажлын албаны дарга, Лхагваагийн Алтангэрэл Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын инженер, дэд бүтцийн газрын дарга, Тавантолгой түлш ХК-аас Цэдэндамбын Эрдэнэбаяр гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч, Доржбаатарын Өлзийбат ерөнхий технологич, Хишигтогтохын Ариунзаяа Хөрөнгө оруулалт, төлөвлөлт, эдийн засгийн хэлтсийн дарга.

1 дэх асуудал энэ өвөлжилтийн бэлтгэл хангах хүрээнд хийгдэж байгаа ажлын талаарх Нийслэлийн Засаг дарга, Улаанбаатар хотын захирагчийн мэдээллийг сонсох ёстой. Нямбаатар дарга яагаад ирэхгүй байна вэ энэ Байнгын хороог хүндэтгээд? Лодойсамбуу горимын санал гаргая. Лодойсамбуу микрофон өгөөрэй.

Ч.Лодойсамбуу: Байнгын хорооны гишүүдэд өдрийн мэнд хүргэе. Нямбаатар дарга яасан гэнэ Амартүвшин дарга? Та шууд микрофонгүй хэлчих. Нямбаатар дарга гадаад хүн тосоод, гадаад хүний гар барих гээд явчихсан юм байна. Одоо бол Нямбаатар дарга намын бүлэг дуудаад ирдэггүй, Байнгын хорооны хуралдаан мэдээлэл авъя гээд ирдэггүй. Зөвхөн өөрийнхөө хуулийг хэлэлцүүлэх болохоор орж ирдэг, Их Хурлын хянан шалгах эрхээ хэрэгжүүлье гэхээр саад учруулдаг дандаа, маш олон удаа давтагдаж байгаа. Тэгээд өнөөдөр Нямбаатар дарга өөрөө мэдээлэл өгөхөөр энэ Байнгын хорооны мэдээлэл дээр ингээд тов дээр туссан байсан. Тийм учраас Нямбаатар даргыг өөрийг нь иртэл энэ асуудлыг хойшлуулъя гэдэг горимын саналтай байна.

Б.Бейсен: Энэ өвөлжилтийн бэлтгэл ажилтай холбоотой нөгөө гадаадаас 130-аад тэрбум төгрөгөөр түлш худалдаж авна гээд асуудал гарсан шүү дээ сайжруулсан түлш коксожсон гээд. 226 билүү? Тэгэхээр энэ ард иргэдээс ч ийм асуудал ярьж байгаа. Даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар заавал энэ Нямбаатар дарга танилцуулга хийх ёстой Байнгын хороон дээр. Энэ 2 Байнгын хороо хамтарч хуралдаж байгаа учраас энэ горимын саналаар санал хураая. Хойшлуулъя гэсэн санал хураая. Санал хураалт. Гишүүд санал хураалтад бэлдье, хуруу уншуулах юм байна шүү. Санал хураалт эхний 1 дүгээр асуудлаар хойшлуулъя гэсэн санал. Гишүүд хуралдаа ирээрэй. Ирцэд ороо, эхлээд ирцэд ор. Золжаргал гишүүнд микрофон өгье. Золжаргал гишүүний микрофоныг.

Ж.Золжаргал: Санал өгч чадсангүй. Горимын санал гаргаад, саяын горимын саналыг хүчингүй болгох саналаар санал хурааж өгнө үү?

Бейсен: Ирцэд орсон гишүүд Байнгын хорооны хуралдаа ирье. Бадамсүрэн гишүүн, Мандхай гишүүн, Пүрэвдаваа гишүүн. Золжаргал гишүүний саналаар саяын хураасан саналыг хүчингүй болгох санал хураалт явуулъя. Санал хураалт. Гишүүд санал хураалтад бэлдье. Саяын санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт. Лодойсамбуу гишүүний гаргасан санал, горимын саналаар санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлдье. 1 дэх асуудлыг хойшлуулах гэсэн юугаар санал хураалт явуулъя. Санал хураалтад бэлдээрэй гишүүд. Санал хураалт. 1 дэх асуудлыг хойшлуулъя гэсэн горимын санал 52 хувиар дэмжигдсэн учир нэг дэх асуудлаа хойшлуулъя. 2 дахь асуудалд орёе. 1 дэх асуудлыг

Нямбаатар даргыг байлцуулаад хэлэлцье гэсэн саналаар энэ 1 дэх асуудлаа хойшлууллаа.

Нэг. “Тавантолгой түлш” ХХК-ийн үйлдвэрлэл, технологийн үйл ажиллагааны талаар шалган судлах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий хянан шалгах ажлын хэсгийн санал, дүгнэлт

2 дахь асуудал Тавантолгой түлштэй холбоотой асуудал байгаа шүү дээ. Хотынхон байж байгаарай. 2 дахь асуудал. 2 дахь асуудалд оръё. Тавантолгой түлш ХК-ийн үйлдвэрлэл технологийн үйл ажиллагааны талаар шалган судлах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий хянан шалгах ажлын хэсгийн санал, дүгнэлтийг сонсох.

Ажлын хэсэг нь Нийслэлийн Засаг даргын Тамгын газар Амгаланбаярын Амартүвшин Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч, Тавантолгой түлш ХК-аас Цэдэндамбын Эрдэнэбаяр гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч, Доржбаатарын Өлзийбат ерөнхий технологич, Хишигтогтохын Ариунзаяа Хөрөнгө оруулалт, төлөлт, эдийн засгийн хэлтсийн дарга, Даваасамбуугийн Мөнхбаатар Нийслэлийн агаар орчны бохирдолтой тэмцэх газрын дарга. Санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Энхтуяа танилцуулна. Энхтуяа гишүүний микрофоныг өгье.

Д.Энхтуяа: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2024 оны 02 дугаар тогтоолоор байгуулагдсан Тавантолгой түлш ХХК-ийн үйлдвэр, технологийн үйл ажиллагааг шалган судлах, хяналт шалгалт хийх, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын Аж үйлдвэржилтийн байнгын хорооны 2024 оны 2 дугаар тогтоолоор Тавантолгой түлш хязгаарлагдмал ХК-ийн үйлдвэрлэл, технологийн үйл ажиллагааг шалган судлах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Энхтуяа, гишүүдээр Бадамсүрэн, Лувсанжамц, Мөнхтулга, Очирбат, Пунсалмаа, Пүрэвдаваа, Сарнай, Уянга, Үүрийнтуяа, Энхтүвшин, Энхцэцэг нарын бүрэлдэхүүнтэй ажиллалаа.

Ажлын хэсгийн тайлан, санал, дүгнэлт, шийдвэрийн төслийг Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэгт заасны дагуу бэлтгэн танилцуулж байна. Ажлын хэсэг энэ хугацаанд 3 удаа хуралдаж, Тавантолгой түлш ХХК-аас ирүүлсэн үйлдвэрлэл, технологитой холбоотой 23 багц материал, 5 стандарт, 6 боть санхүүгийн мэдээлэл, дэмжих бүлгийн ажлын явцын тайлан мэдээллүүдтэй танилцаж ажилласан бөгөөд 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр Тавантолгой түлш ХХК-ийн зүүн бүсийн үйлдвэрийн үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцсан болно. Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, дэмжих багийн бүрэлдэхүүнд Монгол Улсын зөвлөх инженер, органик

химийн инженер, анагаах ухааны доктор, хүний их эмч, хуульч, мөн Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны төлөөллийг оролцуулан ажилласан.

Дэмжих багийн гишүүд нь ажлын хэсгийн төлөвлөгөөт үйл ажиллагаанд оролцож, мэргэжлийн дэмжлэг үзүүлэн ажиллаж, нийт 17 удаагийн уулзалт хийж үр дүнтэй ажилласан болно. Тавантолгой түлш ХХК-ийн үйлдвэрлэл, технологийн үйл ажиллагааг шалган судлах, хяналт шалгалт хийх, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн 2025 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн хуралдаанаар ажлын хэсгийн үйл ажиллагааны тайлан, ажлын хэсгийн санал, дүгнэлтийн төсөл болон ажлын хэсгээс боловсруулсан Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцлээ. Та бүхэнд Монгол Улсын Их Хурлын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2024 оны 02 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгээс гаргасан санал, дүгнэлтийг танилцуулж байна.

Үүнд, 1.Ажлын хэсгээс гаргасан санал, дүгнэлт. Тавантолгой түлш ХХК-ийн сайжруулсан шахмал түлшний одоо мөрдөгдөж байгаа MNS56 79 20 22 стандарт нь ахуйн хэрэглээний шахмал түлшний олон улсын нийтлэг жишгийг хангахгүй байгаа тул ахуйн хэрэглээний шахмал түлш техникийн шаардлага нэршлээр шинэ стандартыг нэн даруй боловсруулан батлан хэрэгцээнд нэвтрүүлж, ААН-үүд энэхүү стандартын дагуу зах зээлийн зарчмаар чөлөөтэй өрсөлдөх боломж бүрдүүлэхийг холбогдох байгууллагуудад үүрэг болгох.

2.Эрдэнэс Тавантолгой ХК-аас эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлээр санхүүжүүлсэн 1,5 их наяд төгрөгийг эргүүлэн төлж, ЭТТ хязгаарлагдмал компанийн хувьцаа эзэмшигчдийн хохирол, алдагдлыг барагдуулах арга хэмжээ авахыг Тавантолгой түлш ХХК-д үүрэг болгох.

3.Засгийн газрын шийдвэрээр тодорхойлогдсон зорилтот үр дүндээ хүрээгүй, цаашид хүрэх эсэх нь тодорхойгүй 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 905,8 тэрбум төгрөгийн хуримтлагдсан алдагдалтай санхүүгийн болон үйлдвэрлэл, технологийн чадваргүй энэ байдлаар үргэлжлүүлэн ажиллах боломжгүй Тавантолгой түлш ХХК-ийн өмчлөл, бүтэц, менежментийн оновчтой хувилбарыг судлан, олон нийтийн хяналттай, нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөн зохион байгуулах эсвэл татан буулгах хувилбаруудаас аль үр дүнтэйг сонгон шийдвэрлэхийг холбогдох байгууллагуудад үүрэг болгох.

4.Улс, орон нутгийн төсөв, хөтөлбөрүүдийн хүрээнд Тавантолгой түлш ХХК-ийн үйл ажиллагаатай холбоотой нүүрс баяжуулах үйлдвэр, хагас коксын үйлдвэр, нунтаг кокс бэлтгэн нийлүүлэх төсөл гэх мэтээр санхүүжүүлсэн нийт хөрөнгийн зарцуулалтыг холбогдох хууль хяналтын байгууллагуудаар шалгуулж, улс байгууллагад эд хөрөнгө, санхүүгийн аливаа хохирол, алдагдал, өр төлбөр учруулсан нь тогтоогдвол буруутай этгээдүүдээр нөхөн төлүүлэх арга хэмжээ авах.

Хоёр.Ажлын хэсгийн хяналт шалгалтын болон хуралдааны явцад ажлын хэсгийн гишүүдээс асуулт асууж, дараах асуудлыг саналуудыг гаргасан болно. Үүнд, 1.Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн гишүүн Бадамсүрэн ажлын хэсгийн санал, дүгнэлттэй холбоотой асуулт асууж, хариулт авсан бөгөөд дэмжиж байгаа талаар, 2.Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн гишүүн Пүрэвдаваагаас үйлдвэрийн худалдан авах ажиллагааг эрх зүйн хувьд төрийн нууцаас гаргаж, мэргэжлийн дүгнэлт хийх боломжийг гаргах, олон тооны иргэний амь нас, эрүүл

мэнд хохирсон тул эрх зүйн хувьд гэм буруугийн асуудлыг шийдвэрлүүлэх, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрт дүн шинжилгээ хийх нь зүйтэй талаар, 3.Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн гишүүн Лувсанжамцаас Тавантолгой түлш хязгаарлагдмал хувьцаат компанийн бизнес төлөвлөгөөг 2025 оны 3 дугаар улиралд багтаан боловсруулж, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороонд танилцуулахыг үүрэг болгох нь зүйтэй, 4.Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн гишүүн Очирбатаас ногоон зээлийн хүүгийн татаастай санхүүгийн тогтолцоонд өрх бүр сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэгч болж, орлого олох боломжийг нээж байгаа 10 мянган нарны дээвэр хөтөлбөрийг хамруулж, холбогдох хууль тогтоомж, журамд тусгаж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, 5.Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн гишүүн Энхтүвшинээс нээлттэй компани болгох эсвэл татан буулгах зэрэг хувилбаруудыг шууд заахгүйгээр компанийн өмчийн хэлбэр, бүтэц, менежменттэй холбоотой бүтцийг сайжруулах, санхүүжилттэй холбоотой схемүүдийг илүү оновчтой болгох үүрэг чиглэл өгөх талаар, 6.Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн гишүүн Пунсалмаагаас төслийг либералчлах, түүнчлэн хувийн хэвслүүд хэрэгжүүлэх, өрсөлдөх боломжийг бий болгох шаардлагатай талаар тус тус санал өгч, хуралдаанаар хэлэлцсэн болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Ажлын хэсгийн санал, дүгнэлт болон холбогдох шийдвэрийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Б.Бейсен: Энхтуяа гишүүнд баярлалаа. Санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу, нэрсээ өгнө үү? Тавантолгой түлш. Тавантолгой түлш хувьцаат компанийн үйлдвэрлэл, технологийн үйл ажиллагааны талаар шалган судлах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий Хянан шалгах ажлын хэсгийн санал, дүгнэлт. Идэрбат гишүүнээр тасаллаа. Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууя. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууя.

Ц.Идэрбат: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Тэгээд Тавантолгой түлш компанийн үйл ажиллагаа энэ чинь нэлээн хэдэн жил үргэлжиллээ. Эхлээд ч аятайхан явлаа, сүүлдээ ч хэцүүдлээ гээд зөндөө олон юм болж байна л даа. Тэгээд би нэг л зүйл асуух гээд байгаа юм. Сүүлийн үеийн энэ Их Хурлын гишүүдийн хэлж байгаа, ярьж байгаа, Нийслэлийн ярьж байгаа, хэлж байгаа энэ бүх зүйлүүдээс ер нь юм ойлгохоо болих гээд байна л даа. Энэ өвөл ер нь нийслэлийнхэн яг юу түлэх юм бэ? Багануураас нүүрсээ оруулж ирж нөгөө портер, зил130-аараа авчраад, нөгөө хуучин явдгаараа түлэх юм уу, Тавантолгой энэ саяын яриад байгаа компанийн үйл ажиллагаа үргэлжлээд цаашаа явах юм уу, Хятадаас юм авчирч түлэх юм уу, эсвэл хотоороо хөлдөж үхэх юм уу? Энэ бүүр ойлгомжгүй болж хувираад байна л даа. Тэгэхээр энэ асуудал ер нь яг цаашаа яг яаж явах ёстой юм бэ? Энэ дээр ер нь нэгдсэн нэг шийдэлд хэзээ, яаж хүрэх юм бэ? Энэ чинь ингээд наадам боллоо. Наадмын маргааш намар, 10 сарын 20-р гал түлэхгүй бол болохгүй. Тэгэхээр би энэ дээр яг энэ чинь Нийслэл, Их Хурал, Засгийн газар гээд ингээд хэдэн тийшээ хараад суугаад байх юм уу? Нэг л юмны төлөө явж байгаа гэж ойлгоод байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр нэг нэгдсэн шийдэлд хэзээ, яаж хүрэх юм бэ?

Ердөө ийм 4 сонголт л байгаа юм байна гэж би ойлгосон шүү дээ. Тийм. Хажуугаар нь тэр дулаалга явах юм байна, Их Хурлын гишүүд нэлээн дэмжиж

байгаа. Тэгэхээр чинь дулаан явахын тулд эхлээд галлачхаад, дулаанаа алдахгүй байх л юм яригдана биз дээ? Тийм учраас энэ дээр ер нь яг яах юм бэ? Тэгээд хүн болгон л би ч нүүрс мэднэ, би ч ийм юм мэднэ, би ч ингэнэ, одоо би миний энэ л их зөв зүйтэй, бусад нь тэнэг гээд ингээд би бүр сүүлдээ гайхаад байгаа юм. Тэгээд бидний ингэж ярих яах вэ, тэр гэр хороололд амьдарч байгаа тэр айл ер нь бэлтгэлээ яаж хангах юм бэ? Нүүрсээ түлнэ гэвэл эртхэн юмаа бэлдэх хэрэгтэй тийм үү? Нүүрсээ хаана буулгахаас авхуулаад л энэ чинь хувь хүнд энэ шийдвэр чинь их чухал шүү дээ. Тийм. Тэгэхээр энэ дээр нэг их олон юм ярилгүй, нэг их тойруулалгүй яг тодорхой нэг шийдвэр танай талаас ямар санал байгаа юм бэ? Тэгээд энэ уулзаж нэг талдаа гарах тийм уулзалт юмнууд хийгдэж байгаа юм уу, үгүй юм уу?

Тэгээд тэр анх энэ Тавантолгой түлш үйлдвэр чинь анх байгуулагдаад Улаанбаатар хот өвөл цэнхэр тэнгэр хараад бүгдээрээ сайхан байна л гэж ярьсан шүү дээ. Тэгээд одоо юу нь болохоо болиод ийм болчихдог юм. Нэг их олон юм ярилгүй хэдүүлээ ирэх өвөл юу түлэх вэ гэдэг дээр л ярья.

Б.Бейсен: Хэдэн номер хариулах вэ? 3 номерын микрофон.

Ц.Эрдэнэбаяр: Идэрбат гишүүний асуултад хариулъя. Тавантолгой түлш компанийн захирал, гүйцэтгэх захирал Эрдэнэбаяр. Юу нь болохоо байгаад энэ түлшийг түүхий эдийг сольё гэдэг ийм асуудал гарч ирсэн бэ гэхлээр ерөнхийдөө Багануурын нүүрс буюу түүхий нүүрсийг түлж байхдаа дэгдэмхий их товчхоноор яривал дэгдэмхий 44 хувьтай байсан. 18 онд шилжилт Засгийн шийдвэр гараад ингээд шилжилт хийгээд мидлинг шахмал түлш түлш рүү шилжилт хийсэн. Энэ 22 хувь болгож бууруулсан. 50 хувь бууруулсан гэвэл энэ 50 хувь бууруулсан үр дүн өгсөн. Тухайн үед түүхий нүүрсийг Улаанбаатар хот руу оруулж ирэхгүй байх шийдвэр энэ төрийн хяналт маш сайн ажилласан. Сүүлийн 2 жил утаа ихэссэн шалтгаан түүхий нүүрс маш ихээр орж ирсэн, хэрэглээ өссөн. 19 онд 350 мянга орчмыг борлуулдаг байсан.

Бид түүхий, мидлингээс ахиад нэг шат ахиулъя, үр дүн гаргая гээд судалгаа хийсэн шинжлэх ухааны байгууллагуудтай нийлээд. Баяжуулсан нүүрс рүү орёе, угааж, баяжуулсан эрчим хүчний тэг давхаргын нүүрсийг хэрэглээ гэсэн. Энэ өөрөө утааны шинжилгээ нь хүхэрлэг хий 1,6 дахин, нүүрстөрөгчийн дутуу исэл 1,4 дахин илүү гарсан. Тэгэхлээр үр дүн гарахгүй юм байна. Одоо тэгвэл яах вэ? 23 оны Эрчим хүчний сайдын судалгаа хийх тушаалаар судалгааны үр дүнг бид үндэслэж Эрдэмтдийн зөвлөлд санал тавьсан. Эрдэмтдийн зөвлөлөөс бидэнд үр дүн гарахгүй байна. Нийслэлийн агаар, орчны эрүүл мэндэд ер нь эрүүл мэнд чухал учраас энэ зүйл рүү кокс руу, кокс буюу хагас боловсруулсан кокс, хөх нүүрс рүү ор гэсэн ийм дүгнэлтийг өгсөн. Энийг үндэслээд Үндэсний хорооны тогтоол гарсан. Тогтоолыг үндэслээд бид Төлөөлөн удирдах зөвлөл дээрээ манай Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэр гаргаад, би бол компанийн гүйцэтгэх захирал Төлөөлөн удирдах зөвлөлөөс шийдвэр гараад Хятадаас хөх нүүрс бэлэн бүтээгдэхүүн судал гэсэн шийдвэр гарсны дагуу бид Монгол Улсад хууль мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн дагуу техникийн шаардлагаа боловсруулаад, нээлттэй тендер зарласан ийм асуудал явж байгаа.

Яг одоогоор хөх нүүрсээр буюу хагас коксожсон шахмал түлшээр Нийслэлчүүдийг ирэх өвөл хангана гэсэн компанийн зүгээс төлөвлөлттэй явж байгаа. Техникийн шаардлагыг яаж гаргасан бэ гэхлээр Шинжлэх ухааны академи,

түүний харьяа байгууллага Химийн технологийн хүрээлэн, Баяжуулагчдын холбоо, Эрчим хүчний мэргэжлийн улсуудаас техникийн зөвлөл техникийн, тавигдах техникийн шаардлагыг боловсруулж бид тендерийн бичиг баримтдаа өгөгдөл болгож ашигласан байгаа.

Б.Бейсен: Идэрбат гишүүнд тодруулъя.

Ц.Идэрбат: Би энэ асууж сурч л явдаг юм. Хятадад энэ Бээжин бол манайхаас долоон дор байж байгаад л ердөө хяналт юм байна лээ шүү дээ. Ердөө л хатуу хяналт. Тэгээд манайх хяналтаа хийж чадахгүй байсаар байгаад тэгээд дуртайгаа түлээд, эргээд нөгөө хэвдээ орчихсон. Тэгэхээр одоо танайх бол хөх нүүрс гэж байгаа юм Нийслэлийн зүгээс гэж би ойлголоо. Засгийн газар сая тогтоол гаргахдаа утаа гаргадаг юманд төсвөөс мөнгө өгөхгүй шүү гээд гаргачихсан тийм байх аа, тэгсэн гэж ойлгож байгаа Их Хурал. Засгийн газар болохоор дотоодоосоо шийд гээд ингэж байгаа шүү дээ. Тэгэхээр ер нь энэ 3 өөр юм ярьж байгаа энэ субъектүүд ер нь хэзээ уулзаж, нэгдсэн нэг шийдэлд хүрэх юм бэ? Миний ойлгож байгаагаар хэдэн зуух тавиад л бүгдийг нь шатааж үзээд л, хамгийн багыг нь л сонгочихвол болохоор юм шиг санагдаад байдаг юм. Тэгээд наад нөгөө барьцалдуулагч эд нар чинь Хятадаас хамгийн мууг нь авчирдаг гэсэн дээ, хамгийн хямдыг нь. Санал.

Б.Бейсен: Хэдэн номер, санал юм уу? Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Б.Бат-Эрдэнэ: Энэ нэг мэргэжлийн хүмүүс нь эсвэл ингээд хоорондоо зөрчилдөөд байдаг юм уу, эсвэл энэ ой санамж нь загасны хэмжээнд оччихсон байдаг юм уу би ерөөсөө ойлгохгүй байгаа юм. Нэг юмыг ингээд болно гэхээр бүгд болно гэж шуураад, болохгүй гэхчхэнгүүт бүгд болохгүй гэж шуураад байгаа байхгүй юу. Тэгээд шинжлэх ухаан нь хаана байгаа юм бэ, хаана орхигдчихоод, хаана гээгдчихээд байгаа вэ гэдгийг би ерөөсөө ойлгож өгөхгүй байгаад байгаа юм. Өнөөдөр БНХАУ-аас хөх нүүрс гэж нэрлээд авах гээд энэ тухай яриад байх шиг байна. Одонтуяа сайдын үед ийм шийдвэр гарсан юм шиг байна лээ. Хуучин Тавантолгой түлш компани дээр явж байсан дээр өөр юм явсан юм шүү. Уул уурхайн яам тухайн үеийнхээр Эрдэнэс Тавантолгой компаниас ТЭЗҮ бүх юмыг нь хийгээд өгч байсан. Тэнд бол Шивээ-Овоо, Багануур, Эрдэнэс Тавантолгой 3-ын нүүрсийг урагшаа явуулаад, аль нь хагас кокс болох боломжтой вэ гэдэг судалгаа шинжилгээг нь хийлгээд, Багануурын нүүрс бол хагас кокс болоход хамгийн өндөр боломжтой юм байна гээд Багануурын нүүрсний уурхайг түшиглэсэн хагас коксын үйлдвэр байгуулъя гэдгийг явсан байхгүй юу.

Тэнд Монголд үйлдвэрлэх тухай явсан, гаднаас импортолж авах тухай яваагүй. Тэрийг тухайн үед яаж гуйвуулсан бэ гэхээр Хятадаас нүүрс оруулж ирж авч ард түмнийг угаартуулж байна гэж гуйвуулсан байхгүй юу. Тэр үед 600 билүү, 400 тонн нүүрс орж ирсэн юм. Тэгэхдээ тэр нь өөрөө манай Багануурын нүүрсийг аваачаад хагас кокс болгоод, буцааж оруулж ирээд, зөвхөн лаборатори дээр турших процессыг л явуулж байсан байхгүй юу. Тэр чинь бараг 2 жил гаруй хугацаанд энэ 2 лабораторийн хооронд хийгдээд явсан процесс. Энэ ажлыг 2022 оны 12 сарын 24-ний өдөр нүүрсний хулгай гарсантай холбогдуулаад томилогдсон БЭТ нь зогсоосон. Улаанбаатар хот 500 гаруй мянган тонныг жилдээ түлж байгаа. Тэр хэрвээ ашиглалтад орсон бол 1,7 саяас 1,8 сая тонн хагас кокс үйлдвэрлэгдэх боломж Монгол Улсад өөрөө байсан. Би андуураагүй бол 25 мегабайтын эрчим

хүч, нафта маш олон юм үйлдвэрлэгдэхээр байсан байхгүй юу. Тэгээд энэ яагаад 1 дүгээрт үргэлжлээгүй вэ гэдгийг би асуух гэж байгаа юм? Өнөөдөр та нар импортолж оруулж ирэхээсээ илүүтэй 1 дүгээрт энэ ажил яагаад явахгүй байгаа вэ?

2 дугаар асуудал та бүхэн Тавантолгой түлшний үйлдвэрүүд дээр технологийн алдаа гарсан шүү дээ. Тэнд БНСУ-ын зураг, төслөөр явагдаж байсныг дундаас нь болиулаад Хятадын тоног, төхөөрөмж оруулж ирсэн гэдэг асуудлууд яригддаг. Энэ дээр та бүхэн ямар хариулт өгч чадах вэ?

3 дугаарт сайжруулсан шахмал түлш тэр чигээрээ муу байгаагүй шүү. Энэ дээр технологийн шийдлүүд явах боломж байсан. Энэ технологийн шийдлийг хийгээгүй. Яагаад хийгээгүй вэ гэхээр удахгүй ээлж ээлжээр нь дарга нарыг нь солиод, ерөнхий инженерүүд нь солигдоод явсан учраас энийг мэддэг хүн Тавантолгой түлш дээр үлдээгүй байхгүй юу. Энэ дээр асуулт?

Б.Бейсен: Хэдэн номер, 3 номерын микрофон хариулъя.

Ц.Эрдэнэбаяр: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Тавантолгой түлш компанийн зүүн бүсийн үйлдвэр дээр бол угаах, баяжуулах үйлдвэрийн төсөл явж байсан. Энэ бол нүүрсний хэрэг, Бат-Эрдэнэ гишүүн учрыг нь мэдэж байх шиг байна. Нүүрсний гэгдэх асуудал үүсэж босож ирсэнтэй уялдуулаад ингээд хууль хяналтын байгууллагуудаар ингээд явж байгаа. Үндсэн ТЭЗҮ сүүлд шинжээчдийн дүгнэлтээр үр ашиггүй юм, мянган км үндсэндээ Тавантолгойн бүлэг ордоос нааш нь нүүрс тээвэрлэж ирээд энд угаагаад боловсруулаад үнэтэй бүтээгдэхүүнийг экспортод гаргаад, завсрын бүтээгдэхүүнээр нь энэ шахмал түлш ашиглаад, хаягдлын аж ахуйгаа бас тооцоогүй байна гэсэн ийм хэд хэдэн шалтгаануудаар энэ шинжээчдийн дүгнэлт хүртэл гарсан байдаг юм байна лээ. Тэгээд энэ асуудал хууль хяналтын байгууллагуудаар явж байгаа.

Багануурын нүүрсний уурхайг түшиглээд хагас кокс боловсруулах үйлдвэрийн төсөл хэрэгжиж эхэлсэн юм байна лээ. Тавантолгой түлш, Эрдэнэс Тавантолгой хамтарсан ийм байдлаар шийдээд явъя гээд. Тавантолгой түлш компанийн зүгээс 11 орчим тэрбум төгрөгийн зардал гаргасан байдаг юм. Багануурын элэгдэж хорогдсон байшинг засах 4 тэрбум төгрөгийн зардал гарсан байдаг. ТЭЗҮ боловсруулах шатад 7 тэрбум төгрөгийн зардал гарсан байдаг. Энэ нь болохлоороо хууль хяналтын байгууллагуудаар ингээд шалгагдаад явж байгаа ийм асуудал байгаа.

Техник, дараагийн асуудал, техник, технологийн алдаа гарсан байна гээд. Солонгосын тоноглолоор анх зүүн бүсийн үйлдвэрийг ерөнхийд нь тоноглосон байсан. Хатаах зуухан дээр алдаа гарсан. Маш өндөр чийгтэй бүтээгдэхүүнүүд гарч эхэлсэн. Хөлдүү, бутрамтгай. Энэ градусын зөрөө Монгол орны уур амьсгалд тохирсон тоноглол байсан уу, үгүй юү гэдэг дээр эргэлзээтэй байгаад байгаа юм. Хатаах зуухан дээр уураар хатаадаг ийм технологи сонгочихсон байсан. Зүүн бүсийн үйлдвэр бол үйлдвэрийн дотор орчны бол агаар гадаахдаа мөн л яг адилхан байдаг. Налайхад градуст 30 хэм хүрвэл яг л тэр 30 хэмийн хүйтэнд үйлдвэрлэл явагдаж байдаг. Тэгэхлээр бид техник Тавантолгой түлш компани техник, технологийн шинэчлэлийн хүрээнд уураар хатаадаг, өндөр градусаар хатаадаг ийм тоноглолыг сонгож байж, бид стандартын дагуу чийгийг 6 хувьд барих ёстой, эндээ барьж эхэлсэн. Та бүхэн санаж байгаа бол чийгтэй, нойтон 14,

5 хувийн чийгтэй маш өндөр чийгтэй түлш, нөгөөдөх нь уугаад асдаггүй ийм асуудалд хүрсэн. Энэний гол шалтгаан бол тэр Солонгосын хийгээр хатаадаг ийм технологи сонгосонд л байсан. Сайн технологи байсан уу гэвэл сайн технологи байсан. Тэгэхдээ градусын зөрөө гарсан.

Ерөнхийдөө техник технологийн шинэтгэл гэдэг юм уу, техник ашиглалтын коэффициентыг бид үргэлж сайжруулаад явж байгаа. Ерөнхийдөө Тавантолгой түлш компани техник ашиглалт 62 хувьтай байсныг коэффициентыг нь нэмэгдүүлээд бид зүүн бүсийн үйлдвэр дээрээ төвлөрөөд 82 хувийн техник ашиглалтын бэлэн байдлын коэффициентоор ажиллая. Төвийн бүсийн үйлдвэрийг ажиллуулахыг зогсоосон ийм шийдвэрүүдийг гаргаад ингээд явж байгаа нь энэ. Хариулж дууслаа.

Б.Бейсен: Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Чи худлаа яриад байна шүү дээ. Наадах чинь ерөөсөө ЭТТ-гоос нүүрс тээвэрлэж ирэхэд хол гэдэг юм яригдаагүй шүү дээ. Нүүрс угаах баяжуулах дээр чинь үйлдвэр барих болоод бүх юмнууд нь яваад эхэлсэн чинь усны нөөц нь буруу тодорхойлогдсон гээд усгүй газар үйлдвэр байгуулах процесс явсан учраас наадах чинь зогссон байхгүй юу. Та өөрөө наад ажиллаж байгаа юм бол ажилдаа эзэн байх хэрэгтэй 1 дүгээр асуудал.

2 дугаар асуудал техникийн асуудал шинэчлэлийн асуудал хийгдэж байна л гээд байна. Та нар түүхий эд дээрээ шинэчлэлээ яаж хийх вэ гэдгээ ерөөсөө ярихгүй байгаа байхгүй юу. Наадах чинь яагаад утаа гараад байгаа вэ гэдэг чинь маш ойлгомжтой асуудал шүү дээ. Асалт дээрээ явж байгаа. Хүчилтөрөгч нэвтрэх ямар ч боломжгүй цул хийчихсэн, тэнд л асуудлууд явж байгаа юм. Тэгээд түүн дээрээ би шинэчлэл хийж байгаа юм уу л гэж асууж байгаа юм. Энэ өвөл юу түлэх юм бэ? Та нар миний сонссоноор сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэхгүй байгаа юм байна лээ. Хөх нүүрсийг чинь ингээд ЗГ зогсоож байх шиг байна. Одоо яах вэ?

Б.Бейсен: Эрдэнэбаяр дарга хариулъя, 3 номерын микрофон.

Ц.Эрдэнэбаяр: Уучлаарай би сая энэ тэр усны нөөцийн судалгаа дутуу хийгдсэн гэдэг дээр дутуу хариулсан байна. Ерөнхийдөө Налайхаас 6 тэрбум төгрөг зарцуулж байж усаа шийдсэн. Ер нь таны хэлж байгаагаар усгүй газар баяжуулах үйлдвэр барих төсөл гэдэг энэ бол үнэн. Энийг би дутуу хариулсан байна.

Хойшдоо энэ шийдвэр яаж гарахыг би сайн мэдэхгүй байна. Тэгэхлээр бидэнд 40 мянга орчим мидлингийн нөөц байгаа, энүүгээрээ бэлдэнэ. Хэрвээ ойрын хугацаанд шийдвэр өөр тийшээ гарвал хуучин мидлингийн түлшээрээ бид өвөлжилтийн бэлтгэл ажлаа хангаад явахад техникийн болон үйлдвэрлэлийн процесст алдаа дутагдал гарахгүй.

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Харин тийм. Энэ өвөл яг яах юм бэ л гэж би асууж байгаа юм. Та нар сайжруулсан шахмал түлшээ үйлдвэрлэхгүй гээд үйлдвэрээ тараачихсан юм биш үү, байгаа юм уу? Тэгээд үйлдвэрлэх юм уу, үйлдвэрлэхгүй

юм уу? Энэ жил сайжруулсан шахмал түлш түлэх юм уу, хөх нүүрс түлэх юм уу, импортолж авах юм уу, эсвэл дотооддоо үйлдвэрлэх юм уу? Энэ шийдвэрээ яаралтай гаргаад явахгүй бол энэ өвөл гал алдах хэмжээнд оччихоод байна. Дулааны цахилгаан станц чинь сая турбинтай холбоотой асуудлууд үүссэн. Одоо бид эндээ яаралтай яриад, та нар маань бидний асуултад хариулаад суугаад байх биш, энд яаж шийдлээ гаргуулах вэ гэдэг дээрээ бодит үнэн нөхцөлөө хэлээд, дэмжлэгээ авмаар байгаа байхгүй юу. Энэ чинь Улаанбаатар хотод амьдарч байгаа байнгын амьдарч байгаа 1,7 сая иргэний асуудал болчихоод байна шүү дээ. Тэгээд энэ дээр бид нарын өмнөөс түүх яриад суугаад байх юм. Наад түүхийг чинь бид мэдэж байгаа байхгүй юу даргаа. Энэ өвөл яах вэ гэдэг дээр.../минут дуусав/

Б.Бейсен: Эрдэнэбаяр дарга хариулъя.

Ц.Эрдэнэбаяр: Бид яг одоогийн байдлаар 40 мянган мидлинг шахмал түлшээ үйлдвэрлэнэ гээд үйлдвэрийн техник технологийн хувьд бэлэн байдал хангагдаад ингээд явж байгаа. Үндэсний хорооны шийдвэр гараад, манай Төлөөлөн удирдах зөвлөлөөс шийдвэр гарсны дагуу бид яг одоогийн байдлаар худалдаж авна гэсэн ийм төлөвлөгөөтэй явж байгаа. Энэ шахмал түлшийг түлш өөрөө маш сайн түлш, энэ түүхэн үүргээ гүйцэтгэсэн. Бид яах вэ энэ чанар стандарт, одоо яг энэ Монголд мөрдөгдөж байгаа энэ стандартын таазандаа тулчихаад байгаа байхгүй юу. Энийг илүү сайжруулахад юу хэрэгтэй вэ гэхлээр дараагийн шийдэл маань хөх нүүрс хагас кокс л гэж харж байгаа юм. Түүнээс өмнө явж ирсэн өмнө 5, 6 жилийн түүхийг стандартыг нь бууруулахгүйгээр бид.../минут дуусав/

Б.Бейсен: Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ өдрийн амгаланг айлтгая. Өвөл болох гээд байна л даа. Өвөлжилтийн бэлтгэлээ хангамаар байна. Тэгэхээр зэрэг хэдүүлээ түлшнийхээ нөөцийг бэлдмээр байна. Технологийн дамжлага дээр дам дамаа хатаалтын технологи дээр тодорхой горимын алдагдал гэдэг юм уу, техникийн шаардлага хангагдаж өгөхгүй байгаад байгаа юм бол дулаан цагт нь ахиу түлш үйлдвэрлэх замаар хэрэглээгээ хангах нөөцөө эрт хийж байж хатаалтын түвшнээ сайжруулах ёстой юм биш үү бид хэд чинь? Тэгэхээр та хэд маань шийдэл хүлээгээд үйлдвэрлэлээ зогсоочихоор чинь зэрэг хэрэглээ чинь гарч ирдгээрээ гарч ирнэ. Цаг нь тулгагдаад хүйтний цагтаа үйлдвэрлэл явагдана. Өнөөх хөлдүү нойтон түлш чинь нийлүүлэлтэд орно, улам л утааны чинь хэмжээ нэмэгдэнэ шүү дээ. Энэ чинь өөрөө нэг горимтой ухаантай юм шүү дээ. Тэгээд энийгээ юу гэж тооцоод байна вэ гэж нэг ийм зүйл байна?

2 дахь зүйл одоо мөрдөгдөж байгаа стандарт олон улсын ахуйн хэрэглээний түлшний стандарт хангахгүй байгаа гэдэг дүгнэлт хаанаас гарсан юм бэ? Та хэд шинэчилсэн стандарт батлахаар зэрэг одоо байж байгаа техник технологи чинь түүнийгээ хангаж чадах юм уу? Ямар өргөтгөл, ямар шинэчлэл хийгдэж байж тэр шинээр батлах гээд байгаа стандартыг хангаж чадах юм бэ, тийм төсөөлөл байгаа юм уу? Зүгээр бид хэд ярьчихаад байгаа улсууд юм уу? Үүн дээр нэг хариулт авчихмаар байна.

Эднийтэй би нэг ийм л юм яримаар байна. Байнгын хороон даргаа БОХХАА-н байнгын хороо сонсгол хийгээд энэ асуудлаар шийдвэр гаргачихсан. Тэр шийдвэрийн хэрэгжилт ямар байна вэ гэдэг асуудал байгаад байгаа юм 1. 2

дугаарт тэр шийдвэрийн хэрэгжилтийг хангах хүрээнд үнэхээрийн л агаар, орчны бохирдолд одоо байж байгаа түлш нь болохгүй байгаа юм гэвэл сайжруулалтын гэдэг юм уу, технологи сайжруулалтын гэдэг юм уу, түлшний бүтцийн өөрчлөлт хийх чиглэлээр нэгдсэн шийдлийг нь яаралтай гаргуулахгүй юм уу? Яг Идэрбат гишүүний, Бат-Эрдэнэ гишүүний хэлж байгаа шиг өвөл биднийг хүлээхгүй болдгоороо болно. Их Хурлын бүтцийн хэд хэдэн байгууллага дээр хэдэн зөрөөтэй юм яригдаад л, ЗГ дээр өөр нэг юм яригдаад л, нийслэл дээр нэг юм яригдаад ингэсээр байтал чинь энэ ард түмэн чинь юу түлэхээ мэдэхээ байгаад байдал бүүр дордох юм биш үү энэ чинь? Өнөө иргэдийн эрүүл.../минут дуусав/

Б.Бейсен: Батжаргал гишүүн 1 минут өгье.

Ж.Батжаргал: Тэгэхээр нэгдсэн бодлогогүй, тал бүрд янз бүрийн байдлаар асуудлыг яриад, бараг ний нуугүй үнэнийг хэлэхэд нэгдсэн бодлогогүйн зуд гэдэг нүүрлэх гээд байна л даа. Үүнийгээ өнөө маргаашгүй засаж авч энэ улсуудыг нэг мөр нэг талд нь гаргаж, тэр чанар, стандарт хангадаг түлш элдэв бусын юмаа үйлдвэрлэх барих энэ бүх юмыг нь дэмжмээр байна л даа. Тэгээд энэ шийдэл л хэрэгтэй байна, хамгийн гол юм өнөөдрийн манай ажлын хэсгээс яригдаж байгаа зүйл ч тэр, энэ Байнгын хороогоор хэлэлцэгдэж, шийдэл хүлээгдэж байгаа зүйл нь шийдлийг нь зөв гаргаж өгөх тухай л ойлголт байна. Энийг нь ЗГ-т ямархуу байдлаар чиглэл өгч, хэдий хугацаанд энэнийхээ биелэлт, үр дүнг тооцох юм энэ л чухал. Энэ нийслэлийн иргэдэд энэ чинь, би нэг худлаа бодоогүй бол 600 хэдэн мянган тонн түлшний жилийн хэрэгцээ.../минут дуусав/

Б.Бейсен: Амартүвшин дарга хариулъя, 3 номер. Эрдэнэбаяр дарга хариулъя.

Ц.Эрдэнэбаяр: Техникийн бэлэн байдал гээд дулаанд энийг горимоо тохируулах ёстой, үйлдвэрлэж нөөц бүрдүүлэх ёстой гэвэл үнэн. Тэгэхдээ манайд байгаа нөхцөл бололцоо таардаггүй юм. Дулаанд үйлдвэрлэхлээр маш их хэмжээний түлшийг агуулах газар байдаггүй, агуулахын хомсдолтой байдаг. Жилдээ 500 мянган тонныг ойролцоогоор түлж байгаа. Хоногт Улаанбаатар оргил ачааллын үед нэг цуваа нүүрс буюу 3500 тонныг өдөртөө хэрэглэдэг. Тэгэхлээр 8 сард, 7 сард бид техникийн бэлэн байдлаа, үйлдвэрийн бэлэн байдлаа хангаад ингээд байж байгаа. Борооны улиралтай яг зэрэгцээд ингээд явахлаар нөгөө их хэмжээний чинь нүүрсийг хадгалж болдоггүй юм. Технологийн шинэчлэл гээд үйлдвэр өөрөө маш энгийн учраас технологи, энэ үйлдвэр технологи бол ойлгомжтой.

Үйлдвэрийн удирдлагын хувьд гүйцэтгэх захирлын ажлыг аваад би зургаа орчим сар болж байна. Юун дээрээ тулж байна вэ гэвэл сая Батжаргал гишүүний асуудал шийдэл чухал. Үндсэн түүхий эд 95 хувь нь үндсэн түүхий эд байдаг энэ шахмал түлшний, 5 хувь нь холбогч эд буюу барьцалдуулагч. 95 хувийг 5 хувиар үр дүн гаргахад үнэхээр хэцүү. Тэгэхлээр үндсэн түүхий эд өөрөө Монголд асуудалтай байна, боловсруулсан бүтээгдэхүүн алга. Дээд тал нь угаасан нүүрс ингэж гарч ирж байна. Өмнөх мидлингийн шахмал түлш үнэхээр сайн байсан уу гэвэл сайн байсан, энэ таазандаа л тулчхаад байгаа юм. Эрүүл орчин хэрэгтэй байна, дээр нь энэ утаан дээр үр дүн гаргах нь чухал байна гэдэг дээр л асуудал байгаа. Өмнөхөөрөө явж болно, одоо стандартыг бариад явахад надад ямар ч асуудал алга. Түүхий эдийн асуудал үнэхээр шийдэлгүй газар ингээд үр дүн гаргах гээд явж байгаа миний хувьд үнэхээр хүнд байгаа.

Энийг бодлогын яамд нь ажиллах хэрэгтэй байна, Эрчим хүчний яам, Уул уурхайн яам, шинжлэх ухааны байгууллагууд нь ажиллах хэрэгтэй байна. Нийслэлийг шийд гээд л тэгчихнэ. Нийслэл дээр химийн мэргэжилтэй, уул уурхайн мэргэжилтэй боловсон хүчин алга, манай компанид ч тийм үнэхээр боловсон хүчний гэдэг юм уу үнэхээр хүнд байна. Би ажил авснаас хойш шинжлэх ухааны байгууллагууд болон эрдэмтэд, энэ судлаачид бүгдтэй нь очиж уулзаж байгаа юм. Ямар шийдэл байвал үр дүн гарах вэ? Үнэхээр арга мухардчихаад байгаа. Энэ болохлоор үндсэн түүхий эд гэдэг юмыг л манайхан ойлгоцгоогооч. Ямар ч судлаач дээр очоод Монголд байгаа нүүрсээр үр дүн гаргаадах гэхэд хэлж чадахгүй, би энийг баталгаатай хэлнэ. Тэгэхлээр энийг та бүхэнд уучлаарай хэлчихмээр санагдлаа.

Б.Бейсен: Энхтуяа гишүүн асуулт асууя. Батжаргал гишүүн тодруулъя.

Ж.Батжаргал: Үгүй ээ энэ шийдлийг нь л шуурхай болгох талаасаа ажлын хэсгийн дүгнэлтээ ч тийм байдал руугаа нэг анхаармаар байна. Өнөөдрийн гарах бодвол би шийдэл гарах байлгүй гэж бодоод байна шүү дээ. ЗГ-т нь хугацаатай. тов тодорхой үүрэг чиглэл өгсөн тогтоолоо гаргаж өгөхгүй бол болохгүй. Энэ үнэхээрийн болохгүй байгаа байхгүй юу. Би бодоод байх юм, 500 мянган тонн түлш гээд ярьж байна хэрэглээ. Бидний одоо үйлдвэрлээд байгаа түлш маань бараг 450-аар гардаг билүү дээ тонн нь 450 мянга шиг санаад байна би. Үгүй ээ тэгээд тооц доо, тэрүүгээр тооцоход хэдий хэмжээний валют гадагшлах гээд байна вэ? Тийм боломж бидэнд байгаа юу? Төсвийн чинь орлого бараг 3, 4 тэрбум төгрөгөөр их наядаар тасалдлууд.../минут дуусав/

Б.Бейсен: Батжаргал гишүүн 1 минут.

Ж.Батжаргал: Тэгэхээр аль болох дотоод нөөц боломжоо дайчилж, иргэдийнхээ эрүүл мэнд, хүрээлэн буй орчиндоо хохирол аль болохоор бага өгдөг тийм юмаа хийх юм руугаа нэлээн эртнээс жоохон зүтгэсэн нь дээр байлгүй дээ. Үйлдвэр дээр байгаа агуулах хараад гэдэг юм уу, эсхүл үндсэн түүхий эдийн нөөцлөлтийн агуулах хараад хэдүүлээ үйлдвэрлэлээ гол үедээ хязгаарлаж болохгүй л дээ. Ирсэн түүхий эд нь үйлдвэр лүүгээ шуурхай орж чаддаг, гарсан бүтээгдэхүүн нь хэрэглэгчийнхээ амбаар луу орж чаддаг тийм сүлжээгээ л хийе л дээ хэдүүлээ. Тэгэхгүйгээр хэдүүлээ энэ чинь болохгүй шүү дээ. Нэгэнт л хатаалтын технологи чинь болж өгөхгүй л байгаа юм бол урин дулааны цагт нь үйлдвэрлэж байж хатаалтаа гүйцээх тухай л ойлголт байгаад байгаа шүү дээ энэ чинь. Тэгэхгүйгээр утаа манаруулчихаад, технологи дутуу юм, техникийн нөхцөл нь тийм юм гээд суугаад.../минут дуусав/

Б.Бейсен: Хариулъя 3 номер.

Ц.Эрдэнэбаяр: Хатаалтын технологи өмнө 2 жилийн өмнө асуудалтай байсан. Одоо бид техник, технологийнхоо шинэчлэлийг нөгөө уураар хатаадаг болоод энэ дээр ямар ч асуудал гарахгүй байгаа юм. Босоо хатаагчтай болсон. Өмнө нь хэвтээ хатаагчтай байдаг байсан. Тэгэхлээр энэ технологийг юу гэдэг юм хатааж чадахгүйдээ энэ асуудлыг үйлдвэрлэж чадахгүй байна гээд. Энэ бол тийм юм байхгүй. Бид тэр асуудлаа шийдчихсэн байгаа. Энэ намайг ажил авахаас өмнө ч ажлууд нь хийгдээд, Даваацэрэн захирлын хувьд үед хийгдээд ингээд явж байсан ажил.

Төсвийн хувьд 600 мянган төгрөгөөр үйлдвэрлэж байгаа бид. 600 мянган төгрөг юу байдаг вэ гэхлээрээ тээвэрлэлтийн зардал, цалин хөлсний зардал, барьцалдуулагчийн зардал, тэгээд тодорхой хэмжээнд шуудайд, бас бус шатах тослох материал гэдэг юм уу ийм үндсэн бүтэцтэй. Зардал нь маш энгийн.

Б.Бейсен: 3 номер гүйцээж хариулъя.

Ц.Эрдэнэбаяр: Тэгэхлээр энэ Тавантолгойн хашаанаас ER-ын хашаанаас аваад наашаах зардлыг тооцоод бид 600 мянган төгрөгөөр үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн нэгжид ноогдох бүтээгдэхүүнээ бариад, 150 мянган төгрөгөөр борлуулдаг. Үндсэн түүхий эдийн үнэ ерөөсөө яригддаггүй, үндсэн түүхий эдийг бид баяжуулсан нүүрсээр сольё гээд ингээд тооцоолол хийж байхад ЭТТ-нхон манайх ахиад 300, танайд 300 тэрбум төгрөгийн жилд татаас өгчхөөд, ахиад түүхий эдэд чинь зориулаад ахиад 300 тэрбум төгрөгийн олох байсан орлогоо алдах гээд байна шүү дээ. Энэ дээрээ бодооч гэдэг ийм зүйлийг ярьдаг юм. Ингээд бодвол ахиад энэ нөгөө үйлдвэрлэлийн өртөг маань бүүр сая гараад явчих асуудал байгаад байгаа юм. Энэ бол нийтдээ улсаас л гарч байгаа мөнгө. Өөрийн өртгийг ерөөсөө тооцдоггүй. Тэгэхлээр бид 306000-ыг энэ жил худалдаж авъя, энийгээ хяналттай, хатуу хяналттай төр бол энэ зүйл дээрээ маш их онцгой анхаарч.../минут дуусав/

Б.Бейсен: Энхтуяа гишүүн асуулт асууя.

Д.Энхтуяа: Энэ дээр нэг жоохон хотынхон ирсэн, Тавантолгой түлшнийхэн ирсэн учраас манай гишүүд ер нь ихэвчлэн нөгөө өвөлжилтийн бэлтгэл байдал гэдгээр нь асуугаад байх шиг байна. Манай Тавантолгой түлшний энэ технологийн алдаа гарсан уу гэдэг ажлын хэсгийн санал, дүгнэлттэй холбоотойгоор асуух асуулт гишүүдээс байвал хариулахад бэлэн байна. Ингээд сая ер нь дүгнэлтээ уншсан байгаа. Бидний дүгнэлт дээр юу гарсан бэ гэвэл технологийн алдаа гарсан уу гэвэл гарсан. Тийм учраас 779 хүн өнөөдөр угаартаж нас барчхаад байна, агаарын бохирдол дээд цэгтээ хүрсэн байна, зундаа хөрсний бохирдлыг үүсгэж байна гэсэн ийм дүгнэлт гарсан байгаа. Тийм учраас энэ үйлдвэрийг цааш нь явуулах юм уу, явуулахгүй юм уу, ер нь явуулах боломжгүй, энэ яг байдлаараа цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй байна гэсэн ийм дүгнэлт гарчхаад байгаа. Тийм учраас би нэгэнт Тавантолгой түлшнийхэн ирсэн учраас Эрдэнэбаяр захирлаа та яг намайг энэ ажлын хэсгийн ахлагчаар ажиллаад эхлэхэд дөнгөж ажил авч байсан. Залуу хүн ирээд зөндөө юм хийчихнэ гэдэг үүднээс, яах вэ манай ажлын хэсгийн гаргаж өг гэсэн бүх бичиг баримтыг танай компани хамтарч ажилласан, энэ дээр эхний удаад талархал илэрхийлье. 2-т нь ингээд өнгөрсөн 6 сарын хугацаанд та ямар ч шийдэлгүй сууж байгаа байхгүй юу. Та зоригтой Эрдэнэтээс та дөнгөж ажлаа аваад ирж байсан, зоригтой шийдвэр гаргаад ажиллана гээд ингээд сууж байсан. Өнөөдөр ингээд зундаа үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулахад хатаах газар байхгүй гэхихсэн ийм юм яриад сууж байж болох юм уу нэгд нь?

2-т нь 2018 оноос санал, дүгнэлттэй бол та нараас зөвшөөрч байна уу, үгүй юу гэдэг асуух асуулт байхгүй. Манай ажлын хэсэгт мэргэжлийн хүмүүс ажиллаад, өнөөдөр ийм санал, дүгнэлтээ гаргачихсан байгаа. Тэгэхээр та бүхэн ажлын хэсгийн гаргасан санал, дүгнэлтийг та бүхэнд явуулна. 2018 оноос хойш ЗГ-ын тогтоол болон ЗГ-ын хуралдаанаар 1,4 их наяд төгрөг Тавантолгой түлш компанид

хөрөнгө оруулалт хийсэн байгаа. Энэ хөрөнгө оруулалтыг эргэн төлөгдөх нөхцөлтэй гэхсэн байгаа. Тэгэхээр энэ юуг хотын захиргаанаас асууя, Амартүвшин даргаа. Энэ татвар төлөгчдийн мөнгийг 1,4 тэрбум их наяд төгрөгийг ямар байдлаар төлөхөөр хотын захиргаанаас төлөвлөгөө боловсруулж байгаа вэ?

2-т нь нэлээн мафаантай асуудлууд маш их олон байна. Ер нь анх ингээд энэ ажлын хэсгийг явж байхад энэ худалдан авалтыг үйлдвэрлэл анх хийх худалдан авалтыг төрийн нууцад оруулсан гэсэн ийм зүйл яригдаж байсан. 2022 онд төрийн нууцаас 9 асуудал гарсан. Энэ асуудал дотор Тавантолгой түлшний асуудал ороогүй. Тавантолгой түлш байгууллагын нууцдаа хамааруулж байгаад өнөөдөр 161 тонн 2 дугаар гурил, алтан тарианы 2 дугаар гурил авчихсан өнөөдөр агуулахад чинь байгаа, барьцалдуулагч гэдэг нэрээр авчихсан байгаа. Тэгэхээр төрийн нууцад энэ байгаад байгаа юм уу? Энийг нэг яг тодорхой хэлээд өгөөч. Төрийн нууцад тэр 22 онд гарсан юман дээр яагаад танай энэ худалдан авалт төрийн нууцаас гарсангүй вэ? 2-т дахиад та 2024 онд ажлаа авснаасаа хойш байгууллагын нууцад хамааруулж байгаад энэ барьцалдуулагч гэж энэ 161 тонн гурил авсны энэ асуудал чинь ямар учиртай юм бэ? Энэ хэвлэл мэдээллээр явуулж байгаа энэ.../минут дуусав/

Б.Бейсен: 3 номер хариулах уу? 4 номер Амартүвшин дарга хариулъя.

А.Амартүвшин: Эрхэм гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Энхтуяа гишүүний асуултад хариулъя. 2024 оны 8 сарын 30-ны өдрийн Монгол Улсын Их Хурлын тогтоол буюу 27 дугаар тогтоолоор 27 оны 1 сарын 1-ийг хүртэл Тавантолгой дээр, Тавантолгой түлш дээр яг ингээд гараад 1,4 их наядын өрийг барагдуулах шийдвэр гарсан байгаа, ЗГ-т үүрэг өгсөн байгаа. Тэгээд 2025 оны 1 сарын 14-ний Монгол Улсын ЗГ-ын 18 дугаар тогтоолыг мөн гаргаж, ингээд 27 оны 1 сарын 1-ийг хүртэл хугацаанд шаардагдах нэмэлт санхүүжилтийг тухай бүрд төсөвт тусган шийдвэрлэж ажиллахыг Эрдэст Монгол ХХК, Эрдэс Тавантолгой ХХК төлөөлөн удирдах зөвлөлүүд ингээд тус тус ЗГ-аас ингээд даалгасан байгаа. ЗГ-аас төлнө. Их хурлын тогтоолоор ЗГ-т үүрэг өгөөд, ЗГ нь Эрдэнэс Тавантолгой, Эрдэс Монгол 2 дээрээ барагдуулах үүрэг даалгавар өгсөн байгаа.

Б.Бейсен: Энхтуяа гишүүнд тодруулъя.

Д.Энхтуяа: Амартүвшин даргаа бид ингээд сонсож байгаа улсуудыг ямар хариулт өгөөд байна вэ? Энэ авсан газраасаа, авсан газрыг нь эргүүлээд өрөө төл гэсэн утгатай ЗГ-ын шийдвэр гараад байгаа юм уу наана чинь? Ерөөсөө ойлгохгүй байна энийг. Энэ чинь танайх хар даа би хэлээд байна шүү дээ 2018 оноос 24 оны хооронд 9 удаагийн тогтоол, тэмдэглэлээр 1,4 их наядыг Эрдэнэс Тавантолгой, Эрдэнэс Тавантолгой компаниас танай Тавантолгой түлш компанид өгчхөөд байгаа шүү дээ. Тэгэхээр ЗГ-ын тогтоолоор дахиад энэ өрөө өөрсдөө төл гэсэн ийм тогтоол гараад байгаа юм уу, тэгж ойлгогдоод байх юм, эсвэл би буруу ойлгоод байна уу?

Б.Бейсен: Амартүвшин дарга 4 номер хариулъя.

А.Амартүвшин: Энхтуяа гишүүний асуултад хариулъя. Энэ өөрөө нөгөө хувьцаат компани байгаа болохоор нэгд хувьцаа нь нийслэлд шилжиж ирээгүй. 2-т нийслэлд зөвхөн менежмент нь ирсэн, нийслэл зөвхөн менежментийг л хийж байгаа. Тэрнээс хувьцаа нийслэлд шилжиж ирээгүй, янз бүрийн тийм асуудал

ороогүй. Эрдэнэс Тавантолгой дээр нь байгаа хэвээрээ байгаа. Үгүй шилжиж ирээгүй гишүүнээ. Манайд зөвхөн менежмент л хийгдэж байгаа. Тэгээд менежментийнхээ хүрээнд удирдлагуудыг солиод, тэгээд энэ дараах энэ ажлуудыг хийгээд явж байгаа.

Б.Бейсен: Батболд гишүүн асуулт асууя. Энхтуяа гишүүн дахин тодруулъя. Энхтуяа гишүүнд микрофон өгье.

Д.Энхтуяа: Эрдэнэбаяр дарга та миний асуултад хариулсангүй. Энэ манай ажлын хэсгийн дүгнэлтийг би та нарт явуулна, та бүхэнд явуулна. Энэ дүгнэлттэй нэгд гэвэл та санал нэгдэж байна уу? 2-т нь тэр байгууллагын нууцад авсан, ер нь энэ технологийн алдаа гарсан чинь тэр барьцалдуулагч 5 хувийнхаа тэр технологийг л өөрчилж, тэр гурил, байгууллагын нууцад авснаас болсон гэсэн ийм дүгнэлтийг ийм ижилхэн дүгнэлт гараад байгаа шүү дээ. Тэгэхээр байгууллагын нууцад яахаараа тэр барьцалдуулагчийг байгууллагын нууцад оруулж байгаад худалдаж авдаг юм бэ?

Б.Бейсен: 4 номер хариулъя, 3 номер хариулъя. Эрдэнэбаяр дарга.

Ц.Эрдэнэбаяр: Намайг би ажил авснаас хойш энэ гурилын асуудал байхгүй. Энэ ковидын үед хил гааль хаалттай үед нэг ийм туршилтын журмаар авч байсан юм байна лээ. Энэ акт, албан шаардлага юмнууд нь тавигдчихсан. Энэ 2020 оны асуудал байгаад байгаа юм, 21 оны асуудал байгаад байгаа юм.

Б.Бейсен: Пунсалмаа гишүүн асуулт асууя. Доошоо жагсаалтаар ирцээр орчхож. Батболд гишүүн асуулт асууя. Үгүй ээ сая доошоо орсон байсан, уучлаарай та.

Р.Батболд: Сайн байцгаана уу та хэд. Энэ нийслэлтэй холбоотой асуудал ёстой үнэндээ гоё юм. Зарим дарга нар нь орж ирээд загнаад байх юм, зарим нь болохоор ингээд ажлаа мэдэхгүй суугаад байх юм. Юу яриад байна вэ? Би уг нь нэг чимээгүй сонсож байгаад гарчихъя гэж бодсон юм. Тэгсэн ерөөсөө асуухгүй бол болохгүй юмнууд гарч ирээд байгаа юм. Үгүй ээ та нар энэ түлш үйлдвэрлэсэн чинь стандартад нь тулчхаад бид ийм түлш л хийхээс өөр аргагүй болчхоод. Үгүй ээ юу яриад байгаа юм бэ? Та нар чинь тэр түлшээ сайжруулж байгаа юм бол тэрийгээ гаргачхаад, ийм стандартаар хийвэл ийм болж байна гэж гаргадаггүй юм уу? Стандарт нь л ийм болохоор бид ингээд л байж байна гээд ийм ямар сонин юм ярьдаг юм бэ? Өөрийн өртгийг өнөөдрийг хүртэл тооцоогүй явсан одоо бол ингээд нэмэгдэх гээд байгаа юм гээд. Үгүй ээ танай үйлдвэрийн чинь хувьд энэ байгуулагдсанаасаа хойш энэ бараг 7, 8 жил ямар ч өртөг тооцохгүй явдаг юм уу, юу яриад байна вэ би бүр гайхаад байна. Энэ чинь 6 сар байгууллага толгойлж явчхаад одоо ингээд шийд гаргах гэхээр болохгүй, энэ яам, тамгын газар нь энэ шийдлээ гаргаж өгөөч гээд өөдөөс ингээд суугаад байх юм. Энэ чинь юу гэсэн үг юм бэ?

Танай Засаг дарга чинь, Нийслэлийн Засаг дарга чинь энэ Тавантолгой түлшийг авчихвал би 2 жилийн дотор ёстой алаад өгнө, ашигтай ажиллуулаад өгнө гээд л тэр 700 хэдэн тэрбум төгрөгийн өр зээлийг нь яах юм, нааш нь, цаашаа шидэж, шидэж л шилжүүлээд авсан шүү дээ. Өөрөө авна, авна л гэж авсан. Номинчимэг гишүүн билүү бас аль энийг нь нийслэлд өгчихвөл алаад өгнө гээд л гүйгээд байсан. Үгүй ээ тэгээд одоо хаана байгаа юм бэ тэр нь? Энэ ажлын хэсгийн

дүгнэлт дээр 700 гаруй тэрбум чинь юу 1,5 их наяд болчихсон явж байх юм. Энэ 8, 9-хөн сарын дотор дахиад 8, 900 тэрбум төгрөг танай дээр бичигдчихээд байгаа юм уу хаашаа юм бэ? Ийм 3, 4 асуулт би сая асуучихлаа шүү. Энэнд бүр яг тодорхой хариулаад өг.

Тэгээд энэ ажлаа хийж чадахгүй, шийдлээ гаргаж чадахгүй яам, тамгын газраас асуугаад байгаа бол эртхэн больчооч дээ, ядаргаатай юм ямар. Энэ өвөл юу түлэх гээд байгаа юм бэ? Наад 280, 60 хэдэн тэрбум ч гэлүү тэр түлш чинь явахгүй шүү дээ. Бид ийм түлшинд зориулаад мөнгө зарцуулахгүй гээд энэ Засгийн газраас тогтоол шийдвэр нь гарчхаад байхад чинь та нар тэнд тэгээд юуг нь тендерийг нь зарлаад явж байдаг ямар сайхан том толгойтой гоё юм бэ? Үгүй ээ, энэ нэг нийслэл гэдэг нь энэ хаант улс юм уу, вант улс юм уу энэний асуудал ерөөсөө арай дэндэж байна. Та энэ дээр нэг хариултууд өгөөдхөөч?

Б.Бейсен: 3 номер хариулъя, дараа нь 4 номер Амартүвшин дарга хариулъя.

Ц.Эрдэнэбаяр: Батболд гишүүний асуултад хариулъя. Стандарт бид мөрдөгдөж яваа стандарттай. Энэ ер нь стандарт гэдэг бол үндсэн түүхий эд дээр бараг үндсэндээ тохирч байгаа тавьсан стандарт. Энэ стандартыг л бид хангаж явна. Энэ дээр хамгийн гол асуудал нийслэлийн энэ агаар, орчинд чинь үр дүн гарах ёстой. Яг ийм түүхий эдээр энэнээс илүү үр дүн гарахгүй байна гэдэг асуудлаа яриад байгаа юм. Дэгдэмхий бодис хуучин түүхий нүүрс түлж байхад 44 хувийн дэгдэмхийтэй байсан, мидлинг 22 болсон. Ахиад 10 болгох боломж байна энэ нь хөх нүүрс юм гэдэг асуудал ярьж байгаа.

Өөрийн өртөг гээд тэгж байна. Өөрийн өртөг тооцдоггүй биш тооцдог. Асуулт, та хариултыг буруу ойлгосон юм шиг байна. ER-раас үнэгүй 5 жилийн хугацаанд мидлингийг нийлүүлж ирсэн, энэ цаанаа татварын хөнгөлөлт, агаарын бохирдлыг бууруулах энэ компанийн тодорхой хэмжээний хөнгөлөлт үзүүлдэг байсан юм байна лээ. Тэрийг бол бид мэдэхгүй. Ер нь үндсэн түүхий эд өөрөө өртөгтэй шүү дээ. Энэ үндсэн түүхий эдийн өртгийг бид бодох ёстой. Тээвэр, ажиллах хүчний зардал, боловсруулах зардал энийгээ л бид 600 мянга гэж яриад байдаг болсон болохоос биш улсаас яг гарч байгаа нь бодит энэнээс өндөр шүү гэдгийг хэлээд байгаа юм.

Б.Бейсен: Амартүвшин дарга хариулъя.

А.Амартүвшин: Батболд гишүүний асуултад хариулъя. Менежмент нийслэл Улаанбаатар хотод шилжиж ирэхэд Тавантолгой ТТТ буюу 2 мянга гаруй, 2003 ажилтантай байсан. Менежментийн дахин зураглалыг хийгээд, менежментийн үйл ажиллагааг нь жигдрүүлээд, бүтээмжийг 63 хувиас 80 гаруй хувьтай болгосон, 86 хувьтай болгосон. Дээрээс нь хүн хүчний ажлыг ингээд 1600 дотор ингээд багтаасан явж байгаа. Хамгийн гол бид нийслэлийн зүгээс хэлээд олон нийтэд болон та бүхэнд хэлээд тайлбарлаад байгаа нь бид мидлингийг алттай хольсон ч энэнээс дээш үзүүлэлт гарахгүй болчхоод ингээд байгаад байна. Өнгөрсөн өвөл бид агаар бохирдол ямар байсан билээ? Дахиад бид мидлингээ ашиглаад, дахиад энэ шахмал түлшээ гэвэл яг л ийм адилхан өвлийг бид угтаж өнгөрөөнө. Тийм болохоор бид энэ хагас кокс буюу энэ жигнэсэн.../минут дуусав/

Б.Бейсен: 4 номер гүйцээж яриулъя.

А.Амартүвшин: Тийм болохоор нийслэлээс дараачийн энэ сонголт буюу энэ хагас коксыг оруулж ирээд, ЗГ-аас тавьж байгаа мега төслүүдийн дунд бол Багануурын нүүрсний үйлдвэрийг түшиглээд хагас коксын үйлдвэр баригдал нь нийслэл дээр энийг ашиглаад явж байя гэсэн санал байгаа. Энэ дээр зөвхөн ганцхан тоо хэлэхэд нийт тоосонцор буюу нөгөө PM2,5 PM10 байгаа. Уушгиар ороод шүүгдэхгүйгээр шууд цус руу ордог энэ нарийн тоосонцор нь шахмал түлш дээр 157 байлаа гэхэд жигнэсэн нүүрс дээр 35 хүртэл буурч байгаа. Энэ 77 хувиар ингээд буурчхаж байгаа байхгүй юу хамгийн гол асуудал. Тэгээд нөгөө өвөл бидний тулгараад байдаг ханиад томуу, хатгаа энэ бүх өвчин чинь энэ шууд энэ РМ нарийн тоостой шууд хамааралтай. Нөгөө жирэмсэн эхчүүдийн урагтай шууд хамааралтай тоосонцор байгаад байгаа байхгүй юу. Хамгийн гол нь нийслэлээс барьж байгаа энэ тоосонцрыг бид буулгахын тулд энэ мидлинг өөрөө буулгаж чадахгүй. Энэ бүтээгдэхүүн нь өөрөө буулгаж чадахгүй. Тийм болохоор энэ хагас коксыг жигнэснийг оруулж ирж энэ агаарын бохирдлыг.../минут дуусав/

Б.Бейсен: Тодруулах юм уу та? Тодруулъя. Золжаргал гишүүн, Батболд гишүүн.

Р.Батболд: Эрдэнэбаяр даргаа энэ стандарт тулчхаад одоо байгаа нь ийм гээд байх юм. Таныг наадхыг чинь одоо болохгүй байгаа бол эсхүл өөр ямар арга байгаа юм, ямар бүтээгдэхүүн, түүхий эд гэдэг юм уу тийм юм хэрэглэж байгаад наадхаа нэг шийдээдэх гэж л тавьсан байдалтай байх юм. Тэгээд яг яалгах гээд байгаа нь мэдэгдэхгүй ингээд стандарт байна л даа гээд суугаад байх юм, ямар зовлонтой юм бэ. 2 жил наад утаагүй болчихсон юм шүү дээ уг нь бол шахмал түлш хэрэглэлээ гээд бүр одоо Багануурын нүүрсээ оруулахаа болиод. Тэр чинь хортой байсан гэсэн үг юм уу, юу гэсэн үг юм бэ? Тэр нь хортой байсан болоод ингээд технологио сольчихсон чинь одоо утаатай болчихоод ингээд балраад байгаа юм уу, яг та нар энийг нэг хариулаад өгөөч. Тэгээд ингээд технологио сольчихсон гээд яриад байх юм. Тэр чинь яг хортой байсан юм уу, хортой байсан юм уу? Хортой түлш түлүүлээд 2 жил энэ хотынхныг хордуулчихсан юм уу?

Б.Бейсен: 5 номер хариулъя.

Д.Мөнхбаатар: Та бүгдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын дарга Мөнхбаатар байна. 2019 онд харьцангуй утаа багатай байсан гэж ярьж байгаа. 2019 онд харьцангуй дулаан өвөл байсан, инверсийн үзэгдэл гэдэг үзэгдэл маань өөрөө харьцангуй тогтуун байхгүй байсан гэж хэлж болно. Инверсийн үзэгдэл гэдэг маань гадаа хүйтэн, дээгүүр хүйтэн агаар, доор хөрсөн дээр агаар хөрчихөөр дулаан агаарыг дээш нь гаргахгүй буюу агаарын солбицол ирэхгүй болоод ирэхээрээ утаа маань бид уулын дээрээс харахад ингээд шугам татчихсан юм шиг ингээд харагддаг энэ маань өөрөө бол инверсийн үзэгдлээр агаарын солбицол ирэхгүй байна гэсэн үг. 19 онд харьцангуй дулаан байсан болохоор инверсийн үзэгдэл 1 дүгээрт байгаагүй.

2 дугаарт Эрдэнэбаяр захирал түрүүн дурдаж ярилаа. Тухайн үед янз бүрийн зүйлийг түлүүлэхгүй, түүхий нүүрсийг түлүүлэхгүй гээд төрийн бүх шатны байгууллагууд хяналтад гараад ажиллаж байсан. Одоо бид энэ жилээс энэ хяналтыг дахин сайжруулаад, дахин энэ түүхий нүүрс бусад зүйлсийг.../минут дуусав/

Б.Бейсен: Батболд гишүүн тодруулъя.

Р.Батболд: Яах вэ нөгөө салхи ажлаа хийгээгүй гэдэг шиг юм боллоо л доо. Дахиад л нөгөөдхөө яриад эхэллээ л дээ. Нэг юуны үзэгдэл гэнэ вэ нэг халуун дулааны л юм яриад явчих шиг боллоо. Тэгээд уг нь ингэж ажилламааргүй байгаа юм. Тэгээд энэ жил яг юугаа түлэх гээд байгаа юм гэдэг шийдэл байгаа юм уу, байхгүй юм уу гэдэг дээр хариулт өгсөнгүй. Яах гээд байгаа юм гэдгээ. Тэгээд ийм нэг арай жоохон хариуцлагагүй байна даа энэ нь. Уг нь хотыг энэ чинь хотын 168 мянган өрх байгаа гэж ярьдаг билүү, тэд нарын түлш түлээг л бэлдэж байгаа улсууд шүү дээ та нар. Тэгээд хамаг үйлдвэрүүд чинь байхгүй болчихсон юм уу? Тэр дулаан байсан, тэр салхи ажлаа хийгээгүй ч арай биш байх. Тэр өвөл салхи ажлаа хийж л байсан байх. Одоо юу гэж ч хэлмээр юм дээ гэж хэлмээр байна наадахыг чинь.

Б.Бейсен: 4 номер, Амартүвшин дарга хариулъя.

А.Амартүвшин: Нийслэлийн зүгээс та бүхэн мэдэж байгаа. Нийслэлийн зүгээс хагас коксыг авч ашиглана гээд саналаа оруулсан байгаа. Үүнийхээ хүрээнд тендерээ хүртэл зарлаад явсан. Тэгээд 2025 оны 6 сарын 5-ны өдрийн нэгдсэн Улсын Их Хурлын 53 дугаар тогтоол батлагдсан байгаа. 53 дугаар тогтоолоор та бүхэн мэдэж байгаа байх гадна, дотноос нүүрс, түлш ингээд худалдаж авахыг ерөнхийдөө хориглосон байгаа. Үүнтэйгээ холбогдуулаад өнгөрсөн хагас сайн өдөр ЗГ-ын гишүүдтэй хотын дарга уулзаад, ЗГ-аас удахгүй асуудлыг Улсын Их Хуралд тавихаар бэлтгэл ажлаа хангаад явж байгаа. Нийслэлийн зүг бол ямар ч байсан мидлингээ ашиглахгүй, хагас коксыг хэрэглэнэ гэж явж байгаа. Өнгөрсөн жилүүдэд 19, 20 онуудад нэгд хараа хяналтаа сайн тавьж ажилласан, түүн дээр маргах зүйл байхгүй. Дээрээс нь.../минут дуусав/

Б.Бейсен: 4 номер гүйцээж хариулъя.

А.Амартүвшин: Тэгээд нүүрсний хэрэглээ нь тухайн үед бага байсан, 350-аас 380 тонныг тухайн жилд хэрэглэж байсан. Одоо бид ингээд 500 тонноор даваад гараад явчхаж байгаа. Дээрээс нь энэ ковидтой холбоотойгоор та бүхэн мэдэж байгаа байх тухайн үед Улсын Их Хурал ер нь хийж байсан байх. Тэр нь нөгөө Эрдэнэт үйлдвэрээс тогны үнийг хөнгөлж байсан тийм ээ. Тэгэхээр ихэнх айлууд мөн цахилгаан халаалт руу шилжиж байсан. Энэ 2 үзэгдлээр ерөнхийдөө утааны юу буурсан. Тэгэнгүүтээ ковид дуусаад буцаад цахилгааны хөнгөлөлт байхгүй болоод нүүрсний хэрэглээ рүүгээ ороод, орох орохдоо 350, 80 тооноосоо шууд 500 тонн руугаа шилжиж ороод ингэснээрээ ингээд бидний өнгөрсөн өвлийн нөхцөл байдал үүсээд байгаа юм.

Б.Бейсен: Пунсалмаа гишүүн асуулт асууя.

Б.Пунсалмаа: Сайн байцгаана уу. Эрдэнэбаяр даргаас асуулт асуугаадахъя. Өмнө түрүү жил бид Тавантолгой түлш компани дээр ажлын хэсэг байгуулагдаад ажиллахад танай үйлдвэр дээр 1000 орчим ажилтан, албан хаагчид ажиллаж байсан. Эдгээр ажилтнууд маань ажиллаж байна уу? Сая таны хэлж байгаагаар манай үйлдвэрлэл түр зогссон байгаа гэсэн ийм зүйл хэлж байна. Тэгэхлээр эдгээр хүмүүс маань ажиллаж байна уу? Бид энэ өвөлжилтдөө бэлдээд тодорхой хэмжээний энэ түлээ нүүрсээ бэлдээд ингээд үйлдвэрлээд байж байх нь бараг зөв гэж санагдаж байна.

Ер нь тэгээд бас нэг саналаа хэлэхэд төрийн өмчийн компаниар заавал энэ сайжруулсан түлшийг үйлдвэрлэх заавал шаардлагатай юу? Яагаад гэхлээр төрийн өмчийн байгууллага төрийн өмчийн байгууллагуудаа хяналт дээрээ ийм асуудалтай байна гэдгийг бид олж тогтоож байна. Өнөөдөр энэ төрийн өмчийн байгууллага төлөвлөлт, гүйцэтгэл, энэ хяналтынхаа байгууллагууд дээр бие биедээ хяналтаа сайн тавихгүй байгаагаас болоод өнөөдөр энэ ахуйн хэрэглээний түлш дээрээ гангийн зориулалттай мидлингээ ашиглачихсан. Үр дүнд нь маш олон хүний амь нас, эрүүл мэнд хохирчихсон ийм асуудал үүсчихсэн байгаа.

Дээрээс нь энэ өртөг зардлын хувьд болохлоор ерөнхийдөө гарч болох зардлаасаа бараг 3 дахин илүү зардлаар энэ өнөөдрийн төсөл босчихлоо гэдэг тооцоог гаргаж байгаа. Хариуцлагын асуудал энэ нэлээд сүүлд яригдаж болно. Одоо бид энэ жил өвөлжилтдөө бэлдэх ёстой одоо зуны дэлгэр цаг дээр. Түүндээ зориулаад бид юу энэ өвөлдөө бид хэрэглэх вэ гэдэг дээр өнөөдрийн энэ хурал анхаарал төвлөрч байгаа. Тэгэхлээр Амартүвшин даргаас асууя. Нийслэлийн хэмжээнд энэ өвөлжилтдөө бэлтгээд бид хөх нүүрс гаднаас захиалж байгаа юм байна. Хэдий хэмжээний хөх нүүрс захиалж байгаа юм бэ? Тэрийг ер нь заавал бүгдийг нь гаднаас авах ёстой юм уу? Энд ерөөсөө 2 л зүйл байгаа. Эсвэл төрийн өмчийн байгууллага үйлдвэрлэж байдаг, үгүй бол гаднаас захиалж байдаг. Яагаад энэ Монгол үндэсний үйлдвэрлэл үйлдвэрлэж болдоггүй юм бэ? Үндсэн хуулиараа энэ хувийн өмч, хөрөнгийг хамгаална гэсэн бид энэ Үндсэн хуулийн заалт байж байна. Тийм болохлоор бид үүнд компани, хувийн хэвшлүүдээ дэмжээд, үндэсний компаниудыг үйлдвэрлүүлэх боломжийг олгомоор байна. Энэ нийт гаднаас захиалах гэж байгаа хөх нүүрснийхээ тодорхой хэмжээнд магадгүй 20 хувь, 10 хувь, 30 хувийг нь Монгол компаниудад өгмөөр байна.

Энэ Монгол хүний эрүүл мэндэд нийцсэн, Монгол яг хүний онцлогт тохирсон үйлдвэрлэлийг Монголчууд бид л үйлдвэрлэнэ. Өнөөдөр бид Монгол компаниудаа дэмжинэ гэж байгаа бол энэ ерөөсөө Монгол хүүхдийн ам руу л хоол халбагадаж байгаа хэлбэр шүү. Энийг бид маш сайн ойлгох хэрэгтэй. Өнөө жил бид яаралтайгаар гаднаас захиалж авч, дараа жил бид дахиад л энэ сайжруулсан түлшийг хэрэглэнэ. Тэр үед Монгол компаниуд хөл.../минут дуусав/

Б.Бейсен: Пунсалмаа гишүүн сунгая, гүйцээж асууя.

Б.Пунсалмаа: Тэр үед Монгол компаниуд хөл дээрээ бат зогсчихсон, үйлдвэрлэгч болчихсон, төдий хэмжээний хагас их наяд төгрөгийн үйлдвэрлэлийг дотооддоо үлдээсэн ийм нөхцөл байдлыг бид энэ жил бий болгож авах ёстой юм байгаа юм. Тэгэхлээр энэ тал дээр манай нийслэл, ЗГ, бид бүх түвшиндээ энийг анхаарч, бодлогоор дотоодын компаниуддаа 20 хувь, 30 хувийг нь ч болтугай үлдээх талаар ажилламаар байна. Та бүгдийн санал ямар байгаа вэ?

Б.Бейсен: Амартүвшин дарга хариулъя, 4 номер.

А.Амартүвшин: Пунсалмаа гишүүний асуултад хариулъя. Манай Монгол Улсад яг өнөөдрийн байдлаар хагас коксын үйлдвэрлэлийг үйлдвэрлэж чадах хэмжээндээ баригдчихсан бол ганцхан компани байгаа. Энэ бол Хятадын 100 хувийн хөрөнгө оруулалттай Ян Сарьдаг гэдэг компани байгаа. Мөн Шадар сайд дээр 2 хагас кокс үйлдвэрлэх чадвартай энэ компанийн эзэд удирдлагыг уулзуулсан. Хоёулаа ингээд хоёулаа бол гаднын хөрөнгө оруулалттай тийм

компани байгаа. Энэ уулзалтаар бол нэг компани нь ашиглалтад орох боломжгүй. Ойролцоогоор 2-оос 3 жилийн дараа үйлдвэрлэж эхэлнэ. Түрүүн миний хэлдэг Ян Сарьдаг хөрөнгө оруулалттай компани нь энэ жилээс зөвхөн 10-аас 20 тонныг туршилтын хэлбэрээр үйлдвэрлэх боломжтой, дараа жилээс ингээд 100-аас 150 тонныг үйлдвэрлэх боломжтой гэдэг мэдээллийг Шадар сайдад хэлсэн байгаа. Тийм. Ямар ч байсан нийслэл бол хамгийн түрүүнд энэ хагас коксыг судлахдаа ингээд дотоодынхоо нэгжүүдээс бүгд судалгааг нь эхлээд, тэгээд ингээд явсан байгаа.

Б.Бейсен: Пунсалмаа гишүүн тодруулъя.

Б.Пунсалмаа: Тэгэхлээр бид ЗГ-ын урт, дунд хугацааны хөтөлбөрүүд гаргаж байгаа. Энэ бол, энэ хөтөлбөрийнхөө дагуу бид дотоодоосоо ийм, ийм стандартын дагуу ийм бүтээгдэхүүн авна гэсэн ийм урьдчилсан захиалга түрүүлээд 1, 2 жилийн өмнө зарлагдаж байсан ийм мэдээлэл үйлдвэрлэгч нарт үйлдвэрлэх урилга хүргүүлж байсан ийм зүйл байгаа юу? Бид энэ юуны төлөө төлөвлөдөг улс орон билээ? Тэгэхлээр энэ төлөвлөж байгаагаа бид ард иргэддээ нээлттэй мэдээлээд зарладаг бол та бүгдийн хэлж байгаачлан яг одоо үзэхэд тийм л үйлдвэр хүчин чадал байна гэхгүй, нөхцөл байдал сайн байх бололцоотой. Тэгэхлээр цаашдаа ирэх жилд ийм бүтээгдэхүүн бид хүлээж авна гэдэг энэ урьдчилсан захиалгыг өгөх энэ боломж бололцоогоо та нар юу гэж харж байгаа вэ?

Б.Бейсен: 3 номер хариулъя, Эрдэнэбаяр дарга.

Ц.Эрдэнэбаяр: Пунсалмаа гишүүний асуултад хариулъя. Манай ажилчдын тухайд гэвэл ажил хүлээж авахад 2000 орчим ажилтантай байсан. Төвийн үйлдвэрийг хаасан, зүүн үйлдвэрийнхээ техник, технологийн шинэчлэлд тулгуурлан тооцооллын хийгээд ер нь бид цаашдаа 1000 орчим хүнтэй цаашдаа үйлдвэрлэл, үйл ажиллагаагаа явуулаад боломжтой юм байна гэж үзсэн. 1000 ажилтан байж байгаа. Сарын хугацаатай бид одоо нийт ажилчдадаа амраасан, засвар шинэтгэлийн ажилд ажилчид маань хэвийн ажиллаж байгаа.

Энэ дотоодын ААН-үүдээс хайсан уу гээд. Ян сарьдаг гэдэг бол төсөл нь ингээд явж байгаа. Энэ Монголд явж байгаа ганц том төсөл бол энэ Багахангайд баригдаж байгаа. Тэгэхдээ бүрэн хүчин чадлаараа ажиллахгүй, ажиллах болоогүй, ашиглалтад ороогүй байгаа, дөнгөж зуухаа байршуулаад ингээд явж байгаа газар байгаад байгаа юм. Бөөрөлжүүтийнхэнтэй өвөл бид уулзсан, эднийхэн бид ийм төсөл эхлүүлэх төлөвлөгөөтэй байгаа гээд. Ер нь таны хэлж байгаа шиг.../минут дуусав/

Б.Бейсен: 5 номер нэмж хариулъя, 3 номер гүйцээж хариулъя.

Ц.Эрдэнэбаяр: Дотоодын компаниудад ерөнхийдөө энэ зүйлүүдийг бид хэлсэн байгаа. Дотооддоо үйлдвэрлэж л байвал энэ бол тантай санал нэг байна. Дотоодынхоо бүтээгдэхүүнийг бид эрчим хүчний нүүрсийг чанарыг сайжруулж байж энэ хөх нүүрс, хагас коксыг бид хэрэглэх ёстой. Багануур Эрдэнэс Монголын харьяанд Багануурын уурхайг түшиглээд, ТЭЗҮ нь боловсруулагдаад, ингээд ЗГ-ын тогтоол гарчихсан бас төрийн нэг төсөл ингээд яваад эхэлж байгаа. Үйлдвэр, технологийн паркийн хүрээнд.

Б.Бейсен: Шижир гишүүн асуулт асууя.

Ө.Шижир: Ер нь бид утаанд хэдэн төгрөг зарцуулсан юм бэ гэдэг асуулт дандаа тодорхойгүй байдаг. Анх 2008 онд улсын төсөв дээр утааны эсрэг гэж мөнгө тавьж эхэлснээс хойш янз бүрийн тоонууд дандаа гардаг юм. Хамгийн их нь мэдээж Тавантолгой түлш 1 тэрбум, 1 их наяд 495,3 тэрбум буюу ойролцоогоор 1,5 их наяд. Агаар, орчныг бууруулах үндэсний хөтөлбөр гээд 603 тэрбум, байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн юун дээр 275 тэрбум, гадаадын зээл, тусламжаар 97,9 тэрбум, Орчны бохирдол бууруулах үндэсний хороон дээр зардал гээд 92,8 тэрбум, Цэвэр агаар сан дээр 69 тэрбум, нийслэл, улсын төсөв дээр ямар нэгэн байдлаар давхардсан байдлаар ингээд 30 тэрбум, ингээд үндсэндээ бид яг өнөөдрийн байдлаар бүдүүн бараг тооцоогоор 3 их наяд төгрөгийг Улаанбаатар хотын утаатай тэмцэнэ гээд зарцуулчихсан байна.

3 их наяд төгрөг гэдэг бол 2016 оны Улаанбаатар хотын төсөвтэй тэнцэнэ. Ер нь улсын төсөвтэй тэнцэнэ 2012 оны. Бид ингээд маш их мөнгөөр тоглож байгаа. Энэ ажлын хэсгийн дүгнэлтийг нь харахаар шахмал түлшинд хэрэглэсэн барьцалдуулагч нь 6 жил огт стандартгүй явсаар ирсэн. Тогтсон стандартгүй олон төрлийн барьцалдуулагчийг 6 жил үйлдвэрлэлдээ хэрэглэсэн нь шахмал түлш хэмээх энэхүү төсөл бүтээгдэхүүн нь шинжлэх ухааны аргачлал, эрүүл мэндийн талаасаа хариуцлагагүй төсөл байна. Стандартын тухай хуулийн 13.4 дээр тохирлын гэрчилгээ гэж гардаг, 6 жил та хэд энэ тохирлын гэрчилгээг аваагүй явчихсан. Үндсэндээ Улаанбаатар хотын иргэд буюу энд Улаанбаатар хотод эрүүл, аюулгүй амьдрах эрхээр Үндсэн хуулиар хангагдаж байгаа эрхийг нь бүдүүлгээр зөрчөөд, 779 хүний амь насыг аваад одчихсон. Одоо энэ үйлдвэрээ бид ашиглахгүй гэж байна.

Гэтэл 2020, 2024 онуудад Тавантолгой түлш компани 5 удаагийн ТЭЗҮ дараалж хийлгээд, нийтдээ 1 сая 720 мянган тонн үйлдвэрлэх хүчин чадалтай ийм үйлдвэрийн хүчин чадалтай болчихсон юм байна энэ тайлан дээр. Гэтэл Улаанбаатар хотын хэрэгцээ нь 600 мянга, хэрэгцээнээсээ давсан юм хийсэн, одоо бид энэ үйлдвэрийг ашиглахгүй, Хятадаас 226 тэрбумаар хагас коксожсон түлш авна гээд сууж байна. Энэ зөвхөн Тавантолгой түлшинд оруулсан 1,5 их наяд төгрөг чинь хайран биш юм уу? Яагаад та нар ийм, би ерөөсөө ойлгохгүй юм. Хүн хөрөнгө гаргасан бол, мөнгө зарцуулсан бол тэрнийхээ араас гүйцэтгэлийг нь хянаад явдаг шүү дээ. Тэгээд яагаад ингээд бүгдийг нь ингээд одоо бид авахгүй, болилоо гэж байгаа юм бэ? Ийм дураараа байдаг болчихсон юм уу? Энэ чинь ерөөсөө ойлгохгүй юм. Энэ Улаанбаатар хотын утааг буулгах чинь туйлын зорилго биш юм уу? 1,5 их наяд зарцуулсан энэ Тавантолгой түлш чинь өөрөө хайран биш юм уу? Зүгээр ингээд хаячих юм уу, одоо болилоо гээд, ерөөсөө Хятадаас авахаа болилоо гээд. Энэний араас ямар нэгэн хяналт шалгалт, аудит хийдэггүй юм уу Байнгын хорооны дарга? Ер нь энэ дээр бас нэг бүр яг тусгайлсан нэг ажлын хэсэг гаргаад ингээд.../минут дуусав/

Б.Бейсен: Шижир гишүүнд 1 минут олгоё.

Ө.Шижир: Яагаад энийг яриад байна вэ гэхээр одоо ингээд өвөл болоод ирэхээр хүн ер нь гэртээ дулаахан байхын тулд л гал түлж байгаа шүү дээ энэ чинь хамгийн энгийн логик. Тэгээд тухайн хамгийн дулаан юу байлгаж чадаж байна тэрийгээ л хэрэглэж байгаа байхгүй юу. Гэтэл цахилгааны үнийг нэмчихсэн, нөгөө цахилгаанаар халаадаг айлууд чинь буцаад түлш рүүгээ орно. Хэн ч сард 2, 3 сая

төгрөг цахилгааны дулаалалтын төлбөрийг төлөөд байж чадахгүй. Энийг нь Доржханд гэдэг сайд үнийг нь нэмчихсэн. Ингээд бид яг бодитоор юу руу орж байна вэ гэхээр буцаад юу түлэх юм бэ гэдэг асуудал руу орж байгаа байхгүй юу. Өнөөдрийг хүртэл 1600 хүнтэй үйлдвэр яагаад ажиллахгүй байгаа юм бэ? Эс үйлдэл хийгээд, Хятадаас коксжих нүүрс аваад, тэрэндээ бэлдээд ажиллаагүй байна шүү дээ та нар. Энэ чинь ажиллаж байх ёстой шүү дээ. Шийдвэр гараагүй байхад ингээд үйл ажиллагаануудаа ингээд түр зогсоочихсон, хүмүүсээ ингээд тараачихсан юм уу, яасан юм мэдэхгүй. Энэ дүгнэлт ёстой аймаар юм байна шүү дээ. Юу вэ, анхнаасаа энэ мидлинг гэдэг чинь үндсэндээ угаасан нүүрсний л хаягдал биз дээ. Тэгээд угаасан нүүрснийхээ хаягдлыг өгөөд тэр компани чинь татвараас 68 тэрбум төгрөг чөлөөлөгдчихөж байна шүү дээ Цэвэр агаар сангаас.

Б.Бейсен: Хэдэн номер хариулах вэ? 3 номер, Эрдэнэбаяр дарга.

Ц.Эрдэнэбаяр: Шижир гишүүний асуултад хариулъя. 600 мянган төгрөгөөр үйлдвэрлэдэг, 150 мянган төгрөгөөр борлуулдаг. Энэ Монгол Улсын ЗГ буюу төрөөс яг энэ ард иргэдэд өгч байгаа бодит дэмжлэг гэж үздэг. Энэний зөрөө бол алдагдал гэж тооцож байгаа юм. Энэ анхнаасаа ЭТТ дээр ер нь нийгмийн хариуцлагын хүрээнд татаас хэлбэрээр явах байсныг тухайн үеийн удирдлагууд нь тухайн үед IPO гаргах гэж байсан. Тэгээд өр хэлбэрээр ингээд нэмээд бичээд явчихсан нь өдий хүртэл ингээд явсан. Энэ эргээд төлөгдөх ямар ч нөхцөл байхгүй. Би, аж ахуйн асуудал, аж ахуй нэлээн эрхэлж байсан хүн учраас энийг яг аж ахуй талаас нь Шижир гишүүнээ харсан юм. Улсаас түүхий эдийн өртөг таны ярьж байгаа сая 68 тэрбум төгрөгийн хөнгөлөлт энэ чинь өртөгтөө шингэх ёстой. Ингээд нийлээд явбал энэ чинь сая хэдэн зуун мянган төгрөгийн өртөг гараад байгаа байхгүй юу үндсэндээ. 600 мянга биш. Үндсэн түүхий эдийнхээ өртгийг тооцдоггүй. Аж ахуй талаасаа харвал одоо яг энэ цаг үе дээр бид яах вэ энэ их хөрөнгийг зарцуулаад яг хуучин хэвээрээ, мидлинг бол хог биш, энэ бас боловсруулсан бүтээгдэхүүн. Энэ дэлхий даяараа л яг энэ стандартаар үг хэллэгээр явж байгаа. Боловсруулсан бүтээгдэхүүн. Үр дүн гаргахгүй байя, яг өмнөхөө стандартаа бариад яв гээд их хөрөнгө зарцуулаад ингээд явбал энэ хуучин хэвээрээ явна.

Үр дүн гаргахын тулд Монгол Улс түрүүн Батболд гишүүний асуусан асуулт, түүхий эдэд л байгаад байгаа байхгүй юу. Үнэхээр чанар стандартад үр дүн гарах түүхий эд гэж алга. Үндсэн түүхий эд маань 95 хувь энийг ойлгох хэрэгтэй, 5 хувь нь холбогч эд буюу барьцалдуулагч. Барьцалдуулагч бол үндсэн түүхий эдийн шаталт дэмжих процесс дээр л нөлөө үзүүлнэ, өөр нөлөө үзүүлж чадахгүй. Нөгөө дарга нар хэлж байна. Үнэнээ хэл ээ, битгий нуу гээд. Монгол Улсад ямар ч шинжээч, эрдэмтдээс асуусан энэнээс илүү үр дүн яг энэ хуучин аргаараа яваад гарахгүй. Бид яах вэ хуучин арга стандартгүй байсан гэвэл худлаа стандарттай. Бид стандартаа мөрдөөд явж байсан. Зарим нэг зүйл дээр алдаа гарч байсныг үгүйсгэхгүй.

Б.Бейсен: Шижир гишүүн тодруулъя.

Ө.Шижир: Дүгнэлтээс л хараад яриад байгаа юм л даа. Энэ стандартыг байхгүй байж байгаад 2024 онд байгууллагын дотоод журмаар стандарт баталсан гэж байгаа юм. Тэгээд сая тохирлын гэрчилгээ, яагаад гэвэл наадах чинь нөгөө тэр хуулийн 13.4 чинь хүний амь насанд аюул занал, хүний амь насанд аюултай бол тохирлын гэрчилгээ авна гэсэн Стандартын хууль байгаа шүү дээ. Тэгтэл та нар тэрийгээ авсан уу, аваагүй юу? Би бол аваагүй 6 жил явчихсан гэж бодож байна.

Энэ чинь 779 хүн угаартаж ямар нэгэн байдлаар амь насаа алдчихаад байхад энийг хүний амь насанд хортой зүйл байсан гэж, байгаагүй гэж хэлэхгүй байлгүй дээ. Тэгээд тэр стандартын юм асуумаар байна?

2 дугаарт энэ 2018 оноос хойш 2024 он хүртэл ингээд 5 удаагийн ТЭЗҮ хийгдсэн юм байна танай дээр. Үүн дээр ТЭЗҮ хийхдээ нүүрсний чанарыг анх харьцуулахдаа энэ тайлан дээр чинь шүү Ухаа худгийн уурхайн баяжуулсан нүүрсийг Налайх, Багануурын нүүрснээс зөвхөн давуу чанарын 3 үзүүлэлтийг нь тусгаж, харин хүхэр, үнслэг байдал гэх мэт эрс муу үзүүлэлт энэ дээр огт дурдаагүй дүгнэлт хийсэн байна гэж байна ТЭЗҮ дээр чинь.../минут дуусав/

Б.Бейсен: Хэдэн номер хариулах уу? 1 номер хариулъя. 1 номерын микрофон.

Д.Өлзийбат: Шижир гишүүний асуултад хариулъя. Тавантолгой түлш компани анх 2019 онд байгуулагдахдаа шахмал түлшний барьцалдуулагчдын судалгааг тухайн үеийн энэ шахмал түлшийг үйлдвэрлэхэд оролцсон эрдэмтдийн зөвлөлүүдээр судалгаа хийсэн байдаг. Энэ судалгаанд бол олон улсад яг барьцалдуулагчийн гэж шахмал түлшний барьцалдуулагчийн стандарт гэж тусдаа биечилж заасан стандарт байдаггүй учраас яг олон улсад нийтлэг хэрэглэдэг барьцалдуулагчдыг ашиглаж ирсэн. Энэ юу вэ гэхээр зэрэг цардуул суурьтай бентонет дүүргэгчтэй барьцалдуулагчийг ашиглаж ирсэн. Тэгээд Монгол Улсад энэ төрлийн стандарт байхгүй учраас манай компани ер нь ямар ч байсан энэ мидлингт тохирсон барьцалдуулагчаа бид байгууллагын стандартыг, стандарттай байлгая. Энэ нь бид худалдан авч байгаа бүтээгдэхүүндээ тодорхой шалгуурыг тавьж өгье гэдэг үүднээс боловсруулаад, 23 оноос хойш боловсруулж байгаад 24 онд.../минут дуусав/

Б.Бейсен: 1 номер гүйцээж хариулъя.

Д.Өлзийбат: Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн газраас байгууллагын стандартыг батлуулаад өнөөдөр мөрдөж байгаа. Тэгэхээр шахмал түлшний үндсэн гол барьцалдуулагч бол аль ч улсад, олон улсад цардуул болон бентонетийн орцтой барьцалдуулагчийг ашиглаж байсан учраас манай компани шахмал түлшиндээ энэ төрлийн барьцалдуулагчийг ашиглаж байгаа. Тэгэхээр байгууллагын стандарт бол өнөөдөр мөрдөгдөөд ажиллаж байна гэсэн үг.

Б.Бейсен: Шижир гишүүн тодруулъя.

Ө.Шижир: Энэ Стандартын хуулийн 13.4 дээр чинь би харин асуугаад байна шүү дээ. Тохирлын үнэлгээнд хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүнийг заавал хамруулж, энэ тохирлын гэрчилгээ авна гээд байна шүү дээ. Тэгээд та нар авсан юм уу гэж би асуугаад байгаа шүү дээ? 6 жил авсан юм уу, одоо байгаа юм уу?

Одоо оруулж ирэх гээд байгаа 226 тэрбумаар худалдаж аваад байгаа Хятадаас авах гэж байгаа тэр коксожсон, хагас коксожсон нүүрс чинь энэ гэрчилгээгээ авсан юм уу? Туршилт хийгдсэн юм уу, хийгдээд үнэлэлт, дүгнэлтүүд нь гарсан юм уу? Ямар зах дээрээс бид бараа авах гээгүй шүү дээ, энэ чинь цаад утга нь нийгэм, хүн, хүний эрүүл, амьд явах эрхийг бид яриад байна шүү дээ. Энэ

тохирлын гэрчилгээ авсан юм уу, аваагүй юм уу? Авсан бол авсан, аваагүй бол аваагүй ингээд нэг хариулаад өгөөч.

Б.Бейсен: 1 номер хариулъя.

Д.Өлзийбат: Шахмал түлш дээр бид тохирлын гэрчилгээг авсан. Тохирлын гэрчилгээний хугацаа дууссан учраас бид 24 онд барьцалдуулагчийн стандарт гарсантай зэрэгцүүлээд бид тохирлын үнэлгээг дахиж хийлгэж, шинэ төрлийн түүхий эд, энэ жил бид баяжуулсан нүүрсээр шахмал түлш үйлдвэрлэх, энэ түүхий эдтэй уялдуулж бид бас тохирлын гэрчилгээг шинээр авах ёстой. Мидлингийн түлшний одоо тохирлын гэрчилгээний хугацаа дуусаж байгаа юм. Тэгэхээр бид одоо баяжуулсан нүүрс дээр тохирлын гэрчилгээтэй болно. Бид хагас коксожсон шахмал түлш дээр тохирлын гэрчилгээ эд нарыг техникийн тодорхойлолт дээр заагаад өгчихсөн байж байгаа.

Б.Бейсен: Очирбат гишүүн асуулт асууя.

Г.Очирбат: Өдрийн мэнд хүргэе. Тавантолгой түлшнийхэн, Улаанбаатар хотынхон яг босож зогсож байгаад уучлаарай бид нарын буруу, 700 хүнээ бурхны оронд явуулчихсан, олон мянган хүүхдүүдээ энэ хорвоогийн өнгө будгийг харуулж чадаагүй явуулчихсан. Тэгээд та хэд ингээд нэг уучлалтаа гуйсан нь дээр байх. Түрүүн энэ Амартүвшин дарга хэлж байна шүү дээ. Уушги шүүж чадахгүй шууд цус руу орж байгаа гээд яриад байна шүү дээ. Тэгээд энэ мидлинг чинь болохгүй байна гээд яг амаараа яриад сууж байна шүү дээ. Тэгээд наадахдаа уучлалт гуйгаад больчих л доо. Та хэн билээ, нөгөө технологийн дарга тийм ээ, 20 оноос хойш тантай уулзаж байна. MNS энэ түлшний стандартыг өөрөө өөртөө зориулж, та хэд баталсан. Өөрөө өөртөө зориулж шүү. Олон улсын стандартуудыг ерөөсөө хараагүй, зөвхөн өөртөө зориулсан.

Яах вэ зүгээр үнэхээр уг нь энэ асуудал нь манай Аж үйлдвэржилтийн байнгын хорооноос Тавантолгой түлшийг хянаж шалгах ажлын хэсгийн л юман дээр ярьж байсан. Тэгээд сүүлдээ өвөлжилт рүү ороод, Тавантолгой руу ороод явж байгаа болохоор асуухаас өөр аргагүй байдалд ороод байна. Энхтуяа гишүүнээ энэ Тавантолгойтой холбоотой та бараг бүүр ийм сонсгол хиймээр юм биш үү? Энэ 32 гишүүн гарын үсэг зураад, сонсоно шүү дээ. Анхнаасаа энэ стандарт дээр алдаатай байсан, анхнаасаа асар их хэмжээний мөнгө угаалт явсан. 3 үсэгтэй компанид зориулсан ажлууд хийгдсэн. Үнэн шүү дээ. Тавантолгойн түлшний очоод инженерүүдтэй уулзахаар энэ гал түлж л байвал, энэ утаа гарч л байвал бид хордож байна гэж хэлдэг биз дээ. Хордсоор байх болно гээд. Энэ технологийн шийдлүүдээ өөр болгохгүй л байна шүү дээ та нар одоо хүртэл.

Тэгээд дахиад бөөн юм ярьсан. Зуухаа солино гэж баахан мөнгө идсэн, сайжруулсан түлш гэж баахан мөнгө идсэн үнэн шүү. Дээрээс нь та нар газ гэж түрүүн баахан зунжингаа солиорлоо. Ямар ч боломжгүй асуудлыг ярьсан. Одоо дээрээс нь ингээд хагас коксожсон нүүрс Хятадаас 226 тэрбум төгрөгөөр авна гээд ичихгүй яриад сууж байна шүү дээ Монгол хүмүүс шүү дээ бид нар. Та хэд босож ирээд уучлаарай гээд больчих л доо. Аягүй инээдтэй байна шүү дээ, яг ингээд залуу хүмүүс адилхан. Дахиад олон Монголчуудыг, олон Улаанбаатарчуудыг хордуулаад алах гээд байгаа юм уу, больё л доо хэдүүлээ. Утааны сонсгол дээрээс бүх нийтээрээ л ярьсан шүү дээ. Тэгээд ямар ч шийдэл байхгүй. Өнөөдөр та 3 номер захирал шийдлээ гаргаад хэлэх хэрэгтэй шүү дээ. Энэ бүтэхгүй юм байна,

яг бид ингээд Монголчуудыг алаад байна. Тэгэхээр хэдүүлээ больё, та нар тэр станцаа бариад чадвал чад, нэг бол сэргээгдэхээрээ яваад энийгээ шийдвэл шийд гээд зоригтой шийдвэрүүдээ та нар хэл л дээ.

Улаанбаатар хот дээр тэр олон улсын НҮБ-тай хамтарч баахан энд тэндхийн дүүргүүдэд тэр Зквт-ын сэргээгдэх эрчим хүчний асар их хэмжээний мөнгө үрсэн, хэдэн төгрөг үрсэн юм, үр дүн чинь юу гарсан юм тэрийгээ хэлээд өгчих? Би 5 айл дээр туршаад үр дүн гаргачхаад байна ядаж. Одоо 1 хороо, гудамж, сумаар нь бараг туршдаг юм уу яадаг юм бэ та нарын өмнөөс. Тэрнийхээ үр дүнг хэлчих. Тэгээд түрүүний 2, 3 асуултад хариулаач.

Б.Бейсен: 4 номер, Амартүвшин дарга хариулъя.

А.Амартүвшин: Очирбат гишүүний асуултад хариулъя. Би түрүүн та бүхэнд хэлж байсан. Энэчээнээ хэдүүлээ нэг л зорилготой байгаа. Улаанбаатар хотын агаарын чанарын асуудлыг хэдүүлээ шийдье. Энэ чанарын асуудлуудыг ингээд яая гээд. Улаанбаатар хот маань дундын болон алсын бодлого нь газ руу, дээрээс нь цахилгаан руу шилжих, сэргээгдэх эрчим хүч рүү шилжих энэ бодлогыг бариад явж байгаа. Тэр хооронд нь 5 дугаар цахилгаан станцын барилга, Бөөрөлжүүтийн өргөтгөл. Бид бол одоо энэ ирэх өвөл яг юу түлэх вэ, 2 сар хагасын дараа яг юу түлэх вэ гэдэг асуудлыг ярьж байгаа гэж ойлгож байна. Тийм болохоор нийт манай Улаанбаатар хотод 172 мянган өрх нүүрс түлж байгаа. Тэр нь бид энэ мидлингийг алтаар хольсон ч гэсэн энэ дэвшилт гарахгүй. Энэ бол дээд цэгтээ тулчихсан. Энэнээс дээшээ яавал бид 95 хувь буюу түүхий бүтээгдэхүүнээ солиод, түүхий бүтээгдэхүүнээ бид хагас коксоор сольё. Энэ бол эрдэм шинжилгээнийхэн ч гэсэн бидэнд зөвлөж байгаа, эрдэмтэд зөвлөж байгаа, лабораториуд ч гэсэн шинжилгээнийхээ хариуг гаргачихсан ингээд явж байгаа. Хагас кокс.

Тэгээд энэний харьцуулалт нь, юм түлж л байгаа бол мэдээж утаа гарна. Үгүй ээ харин тийм. Одоо тэгэхдээ харьцуулъя, одоо хэдүүлээ яг буцаад мидлинг рүүгээ явбал яг өнгөрсөн жилийнх шиг. Жишээлбэл мидлингийн тоосонцор нь хоёулаа сая ярьж байсан нөгөө нэг уушгиар шүүгддэггүй чинь 157 гарч байгаа. Харин тийм, үгүй ээ харин тийм.

Сэргээгдэх эрчим хүч дээр нийслэлээс мөнгө гараагүй. Энийгээ Нэгдсэн Үндэстний Байгууллагын UND-с нийтдээ Улаанбаатар хотод 45 айл дээр өнгөрсөн жилээс туршиж эхэлсэн. Энэ дээр нь энэ жилээс өнгөрсөн жилийн гарсан алдаануудыг нь засаад сайжруулах ажил хийгдээд явж байгаа. Энэ ямар ажил гэсэн бэ гэвэл нөгөө цахилгаанаас эрчим хүч, сэргээгдэх эрчим хүч нь зөвхөн нөгөө паараа халааж чаддаг өвөл хүчин чадал нь хүрдэг, батарей нь хадгалж чаддаг. Нөгөө айл чинь хоолоо хийх болохоороо буцаад цахилгаан руугаа төвийн шугам руугаа залгуулдаг, эсвэл буцаж нүүрс түлж хоолоо хийдэг ийм. Энэ дээр нь дахиж техникийн засварууд оруулаад, энэ жилээс дахиад Чингэлтэй дүүрэг дээр ингээд зуух 100 айл дээр ингээд дахиад хийгдээд явж байгаа. Энэ бол UNDP-с ингээд санхүүжилт нь гараад явж байгаа, цаадуул чинь бол энэ жилийнх амжилттай болбол дараа жилээс ингээд масс хэрэглээнд оруулъя гэдэг саналыг явж байгаа.

Б.Бейсен: Очирбат гишүүн тодруулъя.

Г.Очирбат: Та нар тооцоолол бүгдийг нь буруу хийсэн. Зквт-аар тооцсон, 5квт-ын батарей хураагуур хийчихсэн юм байна лээ. Хүний өдөртөө хэрэглэдэг

эрчим хүчний 1квт-ын тооцооллыг хийж чадахгүй та нар ингэж шийдвэр гаргаж байгаа байхгүй юу. Айлуудаа сонгож өгөхдөө ч гэсэн та нар буруу хийж өгсөн юм байна лээ. Тэгээд бүхэл бүтэн ийм нэг төслийг жил дамнуулаад хэрэглэж байна шүү дээ та нар. Одоо сайжруулна гээд яриад сууж байна шүү дээ. Тэгээд энэ ичих хэрэгтэй шүү дээ. Тэр сонгон шалгаруулсан тэр компани чинь дахиад тэр 3 үсэгтэй компани байна лээ шүү дээ. Очоод харсан шүү дээ. Тэгээд ийм арчаагүй байдалд байж болохгүй шүү дээ. Бүх л хөнгөлөлттэй төсөл, хөтөлбөр, зээл бүх юмыг нь том олигархууд хуваагаад авчихдаг. Одоо Тавантолгой түлш дээр чинь тийм л байгаа биз дээ. Түүхий эдийг чинь цаанаас нийлүүлээд яаж байх юм татварын хөнгөлөлт авч байгаа шүү дээ, НӨАТ төлөхгүй байгаа шүү дээ, асар их мөнгө шүү дээ. Та нар залуу хүмүүс энийгээ зоригтой хэл л дээ, тэгээд болиулъя л даа хэдүүлээ тэгэх үү. Жоохон нээлттэй ярья, шийдвэрээ гаргая.../минут дуусав/

Б.Бейсен: 4 номерын микрофон хариулъя.

А.Амартүвшин: Очирбат гишүүнтэй санал нэг байна. Энийг ямар ч байсан бид өнөөдрийг хүртэл энэ Улаанбаатар хотын асуудлыг уламжилж ярьсан. Намайг дунд сургуульд байхад л энэ Улаанбаатар хотын утааг л ярьдаг байсан. Энэ нь явсаар, явсаар 20 жил явсаар байгаад л, явсаар байгаад бидэн дээр одоо ингээд л хүрээд ирж байна. Энэ нэг нэгэндээ энэ асуудлаа уламжилдаг асуудлыг энэ үеэр ингээд дуусгая гэдэг гол шийдлүүдийг гаргаад явж байгаа. Энийг бид хамгийн гол шилжих ёстой нөгөө нэг хүнд шилжилт газ, цахилгаан 2 бол энэ маш том хүнд 2 шилжилт рүү л бид орж байж энэ Улаанбаатар хотын утааны асуудал ингээд бидний толгойны өвчнөөс бүрэн гарна. Энэ нөгөө нэг UNDP-ээс хийж байгаа сэргээгдэх эрчим хүч бол өөрсдөө компаниа сонгон шалгаруулаад явж байгаа. Манайхаас зөвхөн саналыг нь хэлээд, энэ дээр нь ингээд айл хамтарч ажиллаад явж байгаа. Энэ жилээс 6квт-ынхыг оруулж ирж айлуудад туршилт эхэлсэн байгаа.

Б.Бейсен: Гишүүд асуулт асууж дууслаа. Би нэг саналаа хэлээдэхье. Энэ НЗДТГ, Тавантолгой түлшнийхэн тун хариуцлагагүй хариулт өгөөд байна. Үг байгаа. Яагаад гэвэл энэ түлшний үйлдвэрээ цааш нь сайжруулах, хөгжүүлэх биш ер нь тийм юм байхгүй, эрдэмтэд ч байхгүй гэнэ үү тийм асуудал ярьж байна шүү дээ. Юу гэсэн үг вэ? Борооны улиралд хатаах юу байхгүй, агуулах байхгүй гэнэ. Саравч юм, зуны цагт л юм сайн хатна шүү дээ. Өвлийн цагт үйлдвэрлэсэн түлш маань чийг татаад тэр чинь тэгээд л чийг аваад нойтон түлш болно шүү дээ.

Нөгөө талаар тэр босоо, хэвтээ хатаагчтай байсан одоо босоо хатаагчтай болсон гэнэ. Сайжруулахын оронд ийм шалтаг яриад суухын шаардлага байхгүй шүү дээ. Улсын, түрүүн манай Байнгын хорооноос яриад, Улсын Их Хурлын тогтоол гарсан шүү дээ, 53 дээр тогтоол дээр тодорхой заасан, 15 заалттай тогтоол гаргаад бид өгсөн. Гэтэл энийг зөрчөөд та нар тийм Их Хурлын тогтоол зөрчсөн тийм шийдвэр гаргаад, 226 тэрбумд гаднаас түлш худалдаж авах гэж байна. Бид нүүрсээ экспортолж байдаг, гэтэл гаднаас сайжруулсан түлш худалдаж авна гээд ярьж байдаг. Дотоодын үйлдвэрлэлээ хөгжүүлэхийн оронд тийм асуудал ярьж байна. Тун харамсалтай байна шүү дээ энэ чинь. Энэ дээр та бүгд анхаараад, ер нь энэ ажлын хэсэг Үйлдвэржилтийн байнгын хорооноос гарсан учраас Үйлдвэржилтийн байнгын хороо энд бүр Засгийн газарт чиглэл өгөх тогтоол яаралтай гаргуулах шаардлагатай юм байна. Энэ Үйлдвэржилтийн байнгын хорооны гишүүд юундаа дамжуулж хэлээрэй.

Нөгөө талаар одоо энэ агаарын зуны цагт наадмын дараа ингээд намар, 2, 3 сарын дараа тэгээд түлш түлж эхэлнэ. Зуны цагт хатаагаад бэлдээд, үйлдвэрлэсэн түлшээ, хатсан түлшээ шууд айл өрхөд тараах боломж байгаа шүү дээ. Айл өрх бүгд агуулахтай шүү дээ. Ингэж шалтаг яриад, нэг аар, саар юм яриад байх шаардлагагүй байх гэж бодож байна. ЗГ-т бид ч хэлье, Их Хурал дээр ярья. Ингэж байж ард нь гаргахгүй бол энэ асуудал ер нь сайжрахгүй нь. Та бүхэн бас санаачилгатай, идэвх гаргаад ингээд ажиллаад. Тэр шахмал түлшний үйлдвэр байгуулах асуудал тэр Багануур дээр түшиглэсэн байгуулья гэж байна. Сая та бүгд ярьж байна 2 түлшний үйлдвэр бэлэн болсон гэж байна. Тэрийг хурдан оруулах асуудал, Тавантолгой түлш маань юугаа сайжруулах асуудал дээр анхаарахгүй бол энэ чинь 3 их наядын нийтдээ агаарын бохирдол бүгд нийлээд 3 их наядын зардал гарсан шүү дээ. Тэгээд эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй байна. Энэ дээр анхаарч ажиллаарай гэдгийг хэлье. Үг хэлэх гишүүд байна уу, нэрсээ өгөөрэй? Үүрийнтуяа гишүүнээр тасаллаа. Шижир гишүүн үг хэлье.

Ө.Шижир: Сая тэр Тавантолгой түлш компанийн Технологийн захирал шал худлаа ярьсан шүү, бүүр 100 хувь худлаа ярилаа. Энийг энэ хамтарсан Байнгын хорооны хуралдааны тэмдэглэлд заавал оруулмаар байгаа юм. Тохирлын гэрчилгээ авсан гэж хэлсэн шүү сая. Стандарт, хэмжил зүйн газраас албан бичгээр тодруулахад Тавантолгой түлш хувьцаат компанийн үйлдвэрлэсэн сайжруулсан шахмал түлш бүтээгдэхүүнд Стандарт, хэмжил зүйн газраас олгосон тохирлын гэрчилгээ байхгүй болно. Бүтээгдэхүүн, тогтолцооны баталгаажуулалтын газрын дарга Ганзориг гэдэг хүний гарын үсэгтэй ийм албан бичиг. Ингээд Их Хурлын гишүүдийн асуусан асуултад өөдөөс нь харж өгч байгаад бүр жишим ч үгүй худлаа хэлдэг боллоо. Энэ чинь хуулийн хариуцлагатай шүү дээ худлаа хэлэх нь. Одоо яах юм бэ Байнгын хороон даргаа, ингээд байнга ингээд бид асуусан болоод, хүмүүс нь хариулсан болоод ингээд худлаа хэлээд байх юм уу? Худлаа хэлсэн хүнд яах юм бэ, энэ чинь бүр бүхэл бүтэн нэг байгууллагын ажлыг үгүйсгэчихлээ сая, бүр улаан цагаан худлаа ярилаа.

Та нар өнгөрсөн 6 жил нэг ч тохирлын гэрчилгээ аваагүй буюу стандартад нийцсэн гэдэг бүтээгдэхүүн та нар өөрсдөө, өөрөө өөрсдийнхөө баталсан дотоод журмаараа л яриад яваад байгаа болохоос биш Стандарт, хэмжил зүйн газар дээр чинь алга. Монгол Улсад Стандарт, хэмжил зүйн газар эд нар стандартыг хэрэгжүүлэх үүрэгтэй юм. Бүр ингэж худлаа ярина, бүр ёстой аймшигтай худлаа ярилаа шүү та. Ямар нэгэн байдлаар байгууллага нь энэ үйлдлийнх нь төлөө хариуцлага хүлээх хэрэгтэй, хүлээлгэх хэрэгтэй. Энэ чинь 779 хүний амь нас яригдсан шүү дээ, 1,5 их наяд төгрөг яригдаж байгаа шүү дээ. Тэгэхэд ингээд хариуцсан дарга нар нь ингээд орж ирээд шууд худлаа ярьдаг байж болохгүй шүү дээ. Энэ чинь юу гэсэн үг юм бэ.

Б.Бейсен: Мэндсайхан гишүүн үг хэлье.

З.Мэндсайхан: Тавантолгой түлшний ажлын хэсэгтэй холбоотой л үг хэлье дээ. Энэ өмнө Бейсен дарга хөдөө, Байнгын хорооноос ажлын хэсэг гараад хэлэлцүүлэг хийсэн санагдаж байна. Мөн л энэ хүмүүс сууж байсан л даа. Ерөнхийдөө нэг юмыг бид бодитой ярих ёстой байх. Тавантолгой түлшийг байгуулсан нь тухайн үедээ тэр тухайн үеийн сонсголоор, тооцооллоор инженер, техникийн болон эдийн засгийн үзүүлэлтээрээ тухайн үеийн агаарын бохирдолд эергээр нөлөөлжээ гэдэг дүгнэлт гарсан. Тавантолгойн түлш яагаад муудсан бэ гэхээр хатаалт болон тэр мидлинг гэдэг түүхий эдийн үндсэн орцыг нь, орцод

өөрчлөлт орсон учраас техникийн шаардлагаа хангаж чадахгүй учраас утааны асуудал буцаж дэгдсэн гэдэг асуудал яригдсан.

Тэгэхээр Тавантолгойн үйлдвэр муу муухай байсан юм шиг юм бүгдээрээ яриад байх хэрэггүй. Энэ үйлдвэрийн харин бий болчихсон энэ Улаанбаатар хотод бий болчихсон дэд бүтцийг ашиглаад дараагийнхаа юу руу шилжих ёстой. Бид тэр газ руугаа шилжье. Энэ хүмүүс үнэнээ л хэлж байна шүү дээ. Газ руугаа шилжье, хөх нүүрс рүү шилжье. Хөх нүүрс нүүрс рүү шилжихэд цаг хугацаа хэрэгтэй байна. Би бол тэр нүүрс авчраад түл гэж байгаа асуудал, худалдаж авчирч түл гэж байгаа асуудлыг яриагүй байна. Тэгэхээр энэ ажил хийж байгаа хүмүүсээ загнаад баймааргүй байна. Харин та бүгд маань байгаа энэ Улаанбаатар хотод байгаа энэ том дэд бүтцээ ашиглаад энэ чинь түлээ түлшээ хүргэдэг зөндөө л мянга хэдэн зуун цэг байдаг биз дээ, гурван мянга хэдэн зуу ч билүү. Тэгээд тэр дараагийн шат руугаа л ор л доо, тэрийгээ хэл л дээ. Тэгээд л загнуулаад сууцгаагаад байх юм.

Б.Бейсен: Үүрийнтуяа гишүүн үг хэлье.

Д.Үүрийнтуяа: Юуны өмнө ажлын хэсгийг ахалж ажилласан Энхтуяа гишүүндээ би ажлын хэсгийн гишүүний хувьд, нөгөө талдаа Аж үйлдвэржилтийн байнгын хорооны гишүүдийнхээ өмнөөс талархлаа илэрхийлье. Энэ ажлын хэсэг 6 сарын хугацаанд чамгүй олон ажлуудыг амжуулсан. Надад энэ ажлын хэсгийн үр дүнтэй холбоотой хэлэлцэж байгаа асуудал дээр хэд хэдэн санал байгаа юм. Яах вэ өнөөдөр Тавантолгой түлшний үйл ажиллагааг хэлэлцэж байгаа юм шиг нөхцөл байдал руу аваад орчихлоо. Нөгөө ажлын хэсгийн маань гол үр дүнг ярихаасаа илүү компанийн түлшний асуудлыг авч хэлэлцээд, нөхцөл байдал ийм байдал үүсгэж байх шиг байна. Бид ер нь асуудлыг нэг цогцоор нь авч үзмээр байгаа юм, аливаа асуудлыг ярихдаа.

Тавантолгой түлш компани байгуулагдсан цагаас хойш хэзээ, ямар процесс болчхов гэдгийг өнөөдөр бид хэн хүнээр хэлүүлэлгүй бүгдээрээ мэдэцгээж байгаа. Хамгийн сүүлийн процесс 2024 оны 8 сард шиг санагдаж байна, 10 сард билүү нийслэлийн өмчид шилжүүлбэ гэдэг асуудал парламентад орж ирээд, менежментийн асуудлыг өгсөн. Өнөөдөр эрчим хүчний салбар 5 толгойтой байна, энийг нэгтгэж байна, цомхотгож байна, бодлогыг нь тодорхой болгож байна гээд Ерөнхий сайд ярьж байгаатай адилхан Тавантолгой түлш компани өнөөдөр 5 толгойтой, 5 эзэнтэй. 1 дүгээрт нийслэл менежментийг нь хариуцдаг, өмчийн хувьд Эрчим хүчний яам 39 хувь, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар 10 хувь, Эрдэнэс тавантолгой 51 хувь, дээр нь нэмээд Төлөөлөн удирдах зөвлөлтэй. Энд сууж байгаа удирдлагын баг бүрэлдэхүүн ажлаа аваад 6 сар ажиллахдаа 5 удирдлагын алийнх нь нүүр царай шийдвэрийг харж ажиллах вэ гэдэг дээрээ, үндсэндээ бид адуугаар бол 4 хөлийг нь тушчихаад ташуурдаад байгаа шүү дээ.

Тэгээд энэ гаргаж байгаа бодлого, шийдвэрээ бид нэг цэгцтэйнхэн шиг, олигтойхон шиг хийдэг байдлаасаа л эхэлмээр байгаа юм. Үнэхээр нийслэл аваад явна гэсэн бол нийслэлийн удирдлагууд энэ асуудлаа өмчтэй хөрөнгөтэй нь бүгдийг нь шийдэх хэрэгтэй шүү дээ. Тэгээд тодорхой бодлогыг нь гаргаж өгөөд, ажлыг нь хийлгэх хэрэгтэй шүү дээ. Одоо байгаа үйлдвэрлэлээ явуулъя гэвэл өнөөдрийн түвшинд явъя гэвэл ирэх жил энэ өвөл бид утаатайгаа байна л гэсэн үг. Дахиад л угаарын асуудал, угаартаж байгаа хүмүүсийн асуудал, дахиад л Улаанбаатарын утаа, хөрсний бохирдол энэ асуудлууд, дээр нь энд ажиллаж байгаа олон мянган хүний хөдөлмөрийн нөхцөл байдлын асуудлыг ярих хэрэгтэй

болно. Газар дээр нь ажлын хэсгийн гишүүд, Энхтуяа дарга бол гишүүдээ дагуулж очоод үзсэн. Энэ нөхцөл байдлаа өөрчилье, энэ өвөл утаагүй байх аргаа яаж шийдэх вэ гэдэг юман дээр л өнөөдөр анхаарлаа хандуулаад шийдчихмээр байгаа юм. Өмнөх асуудлууд нь тэртээ тэргүй энэ Авлигатай тэмцэх газар, хууль хяналтын байгууллагуудаар бүгдээр нь шалгагдаад явж байгаа юм байна лээ, нэг эцэслэсэн дүгнэлт гарах байх. Нэн тэргүүнд энэ компанийнхаа энэ олон толгойг нэг цэгцэлж, нэг болгооч 1 дүгээрт. Нийслэл энэ асуудлаа манлайлаад авч байгаад хийгээч.

2 дугаарт ирэх өвөл утаагүй өвөлжье гэж байвал нэн тэргүүнд ямар бодлого гарах ёстой юм бэ? Одоо технологийнхоо өөрчлөлтийг хийгээд, хөрөнгө оруулалтаа хийгээд, нөгөө өмнөх хөрөнгө оруулалтынхаа өгөөжийг гаргаад явах нөхцөл байдал өнөөдөр алга болчихлоо шүү дээ. Өнөөдөр бид 7 сар бараг хүрлээ. Галаа түлж эхлэхэд 2, 3-хан сарын хугацаа байна. Энэ хугацаанд бид энэ бодлогынхоо шийдлийг дорвитойхон шиг гаргаад, Нүүрс, химийн цогцолбор, Багануурын нүүрсний уурхайг түшиглэсэн энэ коксожсон нүүрс үйлдвэрлэх энэ төслөө хэзээ эрчимжүүлэх юм бэ, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооныхоо бодлоготой уялдуулаад энэ компанийн асуудлыг нэгтгэж шийдэх нь зүйтэй.

Тэгээд энэ дээр харин Аж үйлдвэржилтийн байнгын хороо, нийслэл, энэ олон өмч эзэмшээд байгаа энэ яам, тамгын газар, хамгийн олон их хувийг 51 хувийг нь эзэмшиж байгаа Эрдэнэс Тавантолгойн удирдлагууд энэ асуудлаа ярих хэрэгтэй шүү дээ. 51 хувийг эзэмшиж байгаа бол өнөөдөр энэ Байнгын хорооны хурал дээр яагаад энэ ТУЗ-н дарга нар, энэ хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл нь байхгүй байгаад байгаа юм. Бид гүйцэтгэх удирдлагыг нь шийдвэр гаргах түвшинд хязгаарлагдчихсан хүмүүстэй нь өнөөдөр асуудал яриад та ажиллаач гээд шахаад суугаад байдаг. Нөгөө бодлогыг нь гаргаж байгаа нөхөд нь яагаад энд суухгүй байгаа юм бэ? Тийм бол энэ асуудлыг агуулгаар нь бүтнээр нь авч үзээсэй гэж хүсэж байна.

Б.Бейсен: Гишүүд үг хэлж дууслаа. Гишүүдийн санал, хүсэлтийг хүлээж авч байна 1 дүгээрт.

2 дугаарт түрүүн та бүгд ярилаа, энэ технологийн горим алдагдсан барьцалдуулагчтай холбоотой, мидлингтэй холбоотой гэж байна. Нөгөө талаар хатаалттай холбоотой гээд юм ярьж байна. Тийм учраас энэ үнэхээр үйл ажиллагааны технологийн горим нь алдагдсан асуудлыг сая энэ ажлын хэсгийнхэн бас тогтоосон байна. Тийм учраас энэ Үйлдвэржилтийн байнгын хороо тогтоол гаргаад, хэлэлцүүлэг, сонсгол хийх юм уу, хамтарч байгаад Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Тавантолгой түлш, бусад саяын компаниудыг оролцуулж байгаад нэгдсэн шийдэлд хүрэх ирэх долоо хоногийн юунд Үйлдвэржилтийн байнгын хороо оруулах хэрэгтэй байна энийг. Тэгж байж шийдэхгүй бол бас эд нарыг загнаад байх ч хэцүү. Нөгөө талаар тэр хатаалтын тоног, төхөөрөмж, агуулахын асуудал байж байна. Зуны цагт саравчны асуудал ч юм уу энийг шийдээд, яаралтай шийдэхгүй бол ингээд утаа нь ирэх жил утаанаас салахгүй юм байна шүү дээ бид. Энэ асуудал дээр эцсийн шийдвэр гаргахыг Энхтуяа гишүүн ажлын хэсгийн ахлагч энийг ахлаад, Үйлдвэржилтийн байнгын хороонд бид бас хэлье. Манай энэ хамтарсан хурлын протоколдоо тусгаарай.

Хэлэлцэх асуудал дууссан тул Байнгын хороодын хамтарсан хуралдааныг хаасныг мэдэгдье. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаан Үндсэн хууль танхимд юм байна.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА